

Зүүдэн доторх зүүд Адал явдалт зохиол

- Нийгмийн сэтгэл зүйн антироман -

С.Зоригийн гэгээн дурсгалд зориулав

НЭГ. ЗҮҮДНИЙ СҮҮДЭР

Мөнхөө маш их даарч байлаа. Агуйн амсраар идэр есийн жавар цан татуулан тачигнана. Тэрхүү жавар тэгэхдээ салхи дагуулан, цас манарган шуурч голд нь ортол хайрна. Мөнхөө жавар үзүүртэй байдгийг анзаарав. Жаврын үзүүр яг л зүү шиг хатгадаг ажээ. Жаврын үзүүр Мөнхөөг юу ч үлдээхгүй болтол нь сийчих адилаар энгэр цээж, ууц нурууг нь дуу алдтал хатгана. Агуй дотор Мөнхөөтэй цуг жавар л хоргодно. Жавар Мөнхөөг агуйгаас гар гэж хөөх адилаар байж суухын аргагүй болгоно. Мөнхөө жаврыг үзэн ядаж байв. Жавар байхгүй бол Мөнхөө агуй дотор хэдэн цагаар ч хамаагүй байгаад байхаар байлаа. Гэвч жавар цаг өнгөрөх тусам улам л түүнийг тарчилгаж агуйн булан руу шахна. Жаврын тачигнан исгэрэх дуутай хамт өлсгөлөн чонын улиан Мөнхөөд сонсогдож байв. Мөнхөөг барьж идэхээр хөөж байсан чонын сүрэг одоо агуйн гадаа иржээ. Чонын сүрэг Мөнхөөг хэрхэн барих тухайгаа хэлэлцэх адилаар дуу дуугаа аван улилдана. Жавар Мөнхөөг агуйн булан руу бүр шахаж орхисондоо ханалгүй түүний өвөр түрийгээр орж иржээ. Мөнхөөгийн бие жаварт хайрагдан юу ч үгүй болтлоо хөшиж, хөлдөж орхижээ. Одоо түүнд жаврын исгэрээ, чонын улиан ялгагдахаа болив. Мөнхөө юу ч сонсохгүй байв. Харин нүд нь бүхнийг сайн харж байлаа. Тас харанхуй агуй дотор түүний нүд өдөр шиг л бүхнийг товч тодорхой харж байв. Агуйн амсраас час улаан гал түүн рүү дөхөж байлаа. Энэ бол гал биш чонын нүд гэж Мөнхөө мэдэж байв. Харанхуйн дунд чонын нүд яг л гал шиг харагддаг аж. Тэгэхдээ яг л дөл нь цохигдсон түүдгийн час улаан цог шиг харагддаг аж. Мөнхөө урьд өмнө чонын нүд гал шиг байдаг гэж дуулж байснаас үзэж байсангүй. Час улаан нүдтэй чонын сүрэг түүн рүү дөхсөөр л байв. Мөнхөөд чонын сүрэг бүр тулж ирлээ. Сүрэг чонын араа шүднүүд нь ч түүнд тодорхой харагдаж байв. Бүх зүйл өнгөрчээ. Мөнхөө чононд баригдаж үхэх хувь заяатай л байсан аж. Мөнхөө яагаад энд ирж чононд бариулах болсноо эргэж санах гээд чадсангүй. Түүнд айж тэвдсэн өөрийнх нь нүд толинд харагдах мэтээр маш тодорхой харагдлаа. Хүүхэд ахуй цагтаа хадны завсар хоргодсон туулайн бүжинг тэрээр том чулуугаар дарж алж билээ. Тэгэхэд тэр бүжин түүн рүү яг л ингэж харж байсныг тэрбээр саналаа. Мөнхөө алагдах гэж байгаа амьтан бүхэн ингэж хардаг юм байна даа гэж тэрхэн зуур бодож амжив. Чонын сүрэг агуйн буланд шахагдаж байгаа Мөнхөө рүү гал шиг хилэнт нүдээ улалзуулан үсэрлээ. Мөнхөө “Амь авраарай, ээж ээ” гэж хашгирав. Гэлээ ч түүний дуу огт гарсангүй. Эрүү, ам нь хөлдсөндөө тас зуурчээ. Жаварт хайрагдсан хүний дуу нь хүртэл царцдаг аж. Мөнхөөгийн голдоо ортол хайрагдсан энгэр цээж рүү нь чонын час халуун шүд орох нь мэдрэгдэж байв. Мөнхөө амь тэмцэж байлаа. Мөнхөө ийнхүү хар дарж зүүдлээд цочин сэрэв. Түүний хамаг биеэс нь хар хөлс асгарчээ. Тэр хув хүйтэн агуйд биш зочид буудлын бүгчим халуун өрөөнд буйдан дээр хэвтэж байлаа. Сарны гэрэл түүний хажууд хэвтээ бүсгүйн биеийг мөнгөлөг өнгөөрөө гэрэлтүүлнэ. Бүсгүйн хөх ер бусын хуял тачаалаар өдөөн хатгах мэтээр сэрийн томбойжээ. Бүсгүй хөлөө эв хавгүйхэн алцайлган хэвтсэнийг хараад Мөнхөөгийн ой гутах шиг болов.

Бүсгүйн амнаас архи, тамхины нялуун үнэх ханхийгээд тэрбээр золтой л огиж орхисонгүй.

Мөнхөө шартжээ. Тархи толгой нь янгинаж өвдөн нэг л харь хөндий юм шиг л болчихсон байв. Өнгөрсөн шөнийнхөө явдлыг эргэн дурсах гээд чадахгүй байлаа. Харанхуйн дунд тэмтчин явсаар унтраалга олон гэрэл асаав. Зочид буудлын ширээн дээр ууж байгаад орхисон шилтэй архинаас стаканд хийж хоёронтаа татсаных нь дараа түүний дотор онгойж, шар нь тайлагдав. Мөнхөө мөнөөх агуйн чононд бариулж байсан зүүдээ эргэж санаад “Хөгийн юм даа. Хүн халууцахаараа даарч байна гэж зүүдэлдэг юм байх даа” гэж бодов. Мөнхөөд зүүд нь сонин биш байлаа. Харин яажшуухан шиг л хийх ёстой юмаа хийчихээд авах мөнгөө авах нь л сонин байв. Өөрийгөө Ху овогт гэж танилцуулсан нүдний шилтэй, янхигар биетэй хижээл эр амласан мөнгөө өгчих юм бол тэр ёстой л Султан хаан шиг болохоор байлаа. Тэр мөнгийг авчих юм бол Улаанбаатарын шавартай гудамжнаас арилж өгнө. Хэсэгтээ л ан хийхгүй. Хөх хотын өвөрмонголчууд дотроос хэн түүнийг хайж олох юм. Ёстой гонж. Нэг хэсэгтээ л бие амар байна. Бээжин, Шанхайн дууч эмсээр жаахан хүслээ хангаж аваад дараа нь ямар нэг юм хийж таарна. Мөнгөтэй байхад юу ч бүтнэ. Мөнхөө ийн бодов. Мөнхөөтэй уулзаж тохиролцсон эр өөрийгөө Ху овогт гэхээр түүний хөх инээд хүрнэ. Хороололд өссөн Мөнхөө дотор хүнийг ямар ч аялгагүй цэвэр халхаар ярилаа ч андахгүй танина. Яаж ч байсан тэр эр Ху овогт биш монгол хүн байлаа. Хятад эцэгтэй болохоор нь Мөнхөөг халхууд хүүхэд ахуй цагт нь “Хужаа, өмхий хужаа” гэж шоолон тавладаг байсан. Мөнхөө халхуудад яснаасаа дургүй. Идэх хоол, орох оронгүй шахам байж халхууд ямар их дээрэлхүү, бардам гэж санана.

Үргэлж л хятад, хужаа гэх түүнийг үзэн ядаж байсан. Ялангуяа хүүхэд ахуй үед нь тамыг нь цайлдаг байсан. Бие жижиг болохоор нь халхууд байнга л шоглож, хүүхэд болгон л илжиг болгон хоёр чихнээс нь зулгаадаг байсан. Халх охидууд яадаг гэж санана. Хаа тааралдсан газраа “Хөөе, хужаа. Өмдөө чирсэн өмхий хужаа. Еэ, еэ, бөөвөө...” гээд л шоолон уурыг нь бардаг байсан. Тийм болохоор Мөнхөө багаасаа халхуудыг үзэн ядаж өссөн. Дунд сургуулийн долоодугаар ангид байхдаа тэр хөрш айлынхаа нэг халх охинд ухаангүй дурласан юм. Тунгалаг цагаан царайтай, онц сурдаг тэр хөөрхөн охиныг Мөнхөө битүүхэн харж, сэтгэлээ баясгадаг байж билээ. Даанч тэр охин Мөнхөөг нэг нүдээрээ ч үл харна. Хааяа хүнгүй гудамжинд түүнтэй хоёулахнаа тааралдахдаа тэр тэсэлгүй мэндэлж орхидог байсан. Хүний урманд тэр охин хариу эс мэндэлнэ. Үзэн ядсан харцаар тас ширвэж орхино. Тэгэхэд Мөнхөөгийн уур аймшигтай хүрч, Хайлаастын гэр хорооллыг тэр чигээр нь шатааж орхимоор санагддаг байж. Тэр үед хүсэл байлаа ч зүрх хүрдэггүй байж. Одоо бол тэр тэгж хүсвэл юу ч болохоос айхгүй хийж орхино. Мөнхөө одоо хүүхэд биш насанд хүрсэн эр. Халхуудаас айж явах хөг нь өнгөрсөн. Юу хүснэ, хүссэн юмаа санаснаараа хийж орхино. Хайлаастын гэр хороолол бүү хэл Улаанбаатарыг ч үнсэн товрог болгохоос сийхгүй. Тэгэхдээ хэзээ ч гоомой юм хийхгүй. Аав нь түүнийг тэгж хүмүүжүүлж чадсан. “Хэзээ ч азаа бүү үз. Бага багаар нь аажмаар хийж байхад нэг л өдөр бүх юм чиний гарт орно” гэж сургадаг байж.

Хүүхдүүд Мөнхөөг “Хужаа, өмхий хужаа” гэж хочлоод байхад тэр аавдаа учиргүй их уурладаг байсан. “Аав хятад болохоор л хүүхдүүд намайг ингэж шоолоод байна. Аав үхчихээсэй. Тэгвэл намайг хүүхдүүд хужаа гэж хочлохгүй” хэмээн гэнэхнээр боддог байсан. Аав нь үхчихсэн. Үхчихсэн ч гэж дээ, яг үнэндээ Мөнхөө алчихсан юм. Өрөнд орчихоод зовж байхад нь аав нь түүнд туслахгүй гэсэн. Тэгэхлээр нь Мөнхөө уурандаа эцгийнхээ хоолойг боож орхисон юм. Өндөр настай эцэг нь түүний боолтыг даалгүй газар дээрээ нас барсан. Энэ тухай чөтгөр ч мэдээгүй. Бүгд л “Настай хүн гэнэтхэн өөд

болчихлоо. Буянтай хүн болохоор үр хүүхдээ зовоосонгүй” гэцгээсэн. Яг үнэндээ энэ бол түүний анхны ан байсан юм. Мөнхөө тэр ангийнхаа үр шимийг ч амссан. Өөрөөсөө харамлан байж хураасан эцгийнх нь чамгүй их мөнгө Мөнхөөгийн өрийг дарж, хэдэн өдрийнх нь зугааг гаргасан билээ. Гэхдээ энэ бол тохиолдлын ан байсан хэдий ч Мөнхөөд ийм замналаар амьдарч болох замыг нээж өгсөн. Дараа нь тэр жинхэнэ анчин болсон. Хар нялхаас нь л дарлаж байсан нэг биерхүү халх залууг Мөнхөө уран аргаар хөнөөж орхисон юм. Олон жил дээрэлхэж байсан тэр залуу бүр эцэстээ дэндээд Мөнхөөгийн үерхдэг хүүхнийг шууд л дээрэмдсэн. Тэр залууг Мөнхөө согтуу явж байхад нь даавуугаар битүү ороосон лантуугаар дагзанд нь ганц цохиж орхисон юм. Нүсэр лантууны цохилтод тэр эр том биеэ яг л сүхдүүлсэн бух шиг нурхийтэл унагаад өөд болсон. Тас харанхуй шөнө байсан болохоор хэн ч түүнийг хараагүй. Угаасаа ч тэр том эрийг Мөнхөө шиг жижигхэн амьтан цохиж унагасан гэвэл хүн итгэхгүй байсан. Тэр хэрэг тэгээд л таг чиг өнгөрсөн. Бодвол нэг согтуу эр явж байгаад дагзаараа юм мөргөөд уначихаж л гэж оношилсон биз.

Тэр эр хэрвээ Мөнхөөгийн лантуунд цохиулаад тэгж унаагүй бол Мөнхөө зүрхэнд нь хутга нэвт шаах байсан. Аз болж тэр залуу газар дээрээ ганц цохилтоор л нам болсон. Харин Мөнхөөгийн тэр анг уг явдлыг мөрдөж байсан цагдаагийн хошууч эр гадарласан л даа. “Чи тэр шөнө хаана, юу хийж байсан бэ? Чамайг сүх бариад хашаанаасаа гараад явж байсан гэж хүн хэлсэн шүү” гээд л улайн цайм тулгаж асуусан. Мөнхөө тэр асуултад барьц алдсан л даа. Тэглээ ч мөрдөн байцаагч эр цааш нь ухааж, төнхөж зовоолгүй “Юу болсныг би мэдэж байна. За, яахав. Эр улс эргэж уулзана аа” гээд явуулсан юм. Тэрнээс хойш мөрдөн байцаагч эр Мөнхөөтэй гайгүй харьцаатай болсон. Нэг удаа бүр итгэл өгч нэг хүнийг агнуулсан юм. Чамгүй ашигтай тэр анг нь Мөнхөө хэнд ч хар авахуулалгүй гүйцэтгэж орхисон. Угаасаа ч зүрх муутай байрын уг хүн нь Мөнхөөгөөс ухаангүй болтлоо айгаад “Миний үхэлд хэн ч буруугүй. Би энэ амьдралаас уйдаж байна” гэж гэрээслэл бичээд Богд уулын аманд өөрийгөө дүүжилчихсэн. Түүнийг өөрийгөө дүүжлэхийг нь үдшийн бүрэнхийд харж зогссон Мөнхөө модон дундуур цааш юу ч болоогүй юм шиг алхаад Улаанбаатар руу орж ирж билээ. Золгүй явдал мэтээр үйлдсэн тэр аллага бас ч таг чиг өнгөрсөн. Харин мөрдөн байцаагч эр Мөнхөөд шанг нь өгөхдөө “Чи цэвэрхэн хийсэн байна лээ. Гэхдээ сонор сэрэмжээ алдаж болохгүй. Би чамд хэрэг болно шүү” гэж заных, учирлах хоёрын дундуур хэлж билээ. Түүнээс хойш Мөнхөө мөрдөн байцаагч эртэй уулзалгүй байж байгаад гурав хоногийн өмнө дуудахад нь очиж уулзсан хэрэг.

Тэгэхэд мөрдөн байцаагч эр “Би чамайг нэг хүнтэй танилцуулна. Чи уулзаад үз. Миний итгэлтэй хүн” гэсэн юм. Тэр хүн нь мөнөөх Ху овогт. Ху овогт Мөнхөөд урьдчилгаа гэж чамгүй их мөнгө өгсөнөө “Яг юу хийхийг чинь дөрөв хоногийн дараа хэлнэ. Би чамд итгэж байна. Чи надад бас итгэх хэрэгтэй” гэсэн юм. Мөнхөөд мөнгө нь сонин байхаас итгэл, сэтгэл бол сонин биш байсан. Үнэхээр тэр амласан мөнгөө өгөх юм бол Мөнхөө Султан хаан л болно. Ху овогт халх хүн байсан. Халхууд шударга хэрнээ гэнэн байдгийг Мөнхөө мэднэ. Аягүй л бол хийх юмаа хийлгэчихээд мөнгөө өгчихөж ч мэднэ. Тийм болохоор Мөнхөө тэр тал дээр санаа зовохгүй байлаа. Ганц санаа зовж байгаа юм бол мөрдөн байцаагч эр. “Мэргэжлийн хүмүүс яаж ч мэднэ. Араас хутга шааж ч мэднэ. Тийм болохоор зайгаа барих хэрэгтэй. Энэ анг нь гайгүй шиг хийчих юм бол арилж өгье. Өөрөө ч холбоотой юм чинь намайг алга болчихвол мань эр баярлаж таарна. Ху овогт ийм их хэмжээний мөнгө хаяж байгаа юм чинь тэр хүн нь их л нөлөө бүхий хүн байж таарна. За,

хэн ч байсан яахав. Надад падлий алга. Гол нь цэвэрхэн л хийх хэрэгтэй. Маргааш Ху овогттой уулзах ёстой. Тэр болтол лай ч байна, зай ч байна. Мөнгө гэдэг хүчтэй юм даа. Таван улаан мөнгө хараад энэ хүүхэн амархан өвөрт орж байна шүү. Мөнгөгүй бол хэн ч биш байна. Ийм жаргал олдох ч үгүй”. Мөнхөө ийн бодон шилтэй архинаасаа дахин хийж татчихаад гэрлээ унтрааж ор руугаа очив. Шар нь тайлагдсан болохоор түүний сэрэл аажмаар хөдөлж эхлэхэд унтаж буй хүүхнийг сэрээхийг оролдон хөхнийх нь толгойг имэрч эхэллээ. Үүр цайх яагаа ч үгүй байв.

ХОЁР. ОЛИГАРХИ

Үдийн цайны цаг болохоос өмнө Төрийн ордонд иргэд нэвтрүүлэх газрын хаалгыг бараг л зад савж хаячихаад ид насны өндөр хөх эр саарал ордны зүг хойд хаалга руу нь гүйх нь холгүй хүрч очив. Залхуу хүрэм удаан хөдөлгөөнтэй нэвтрэх хуудас бичигч эрд тэрбээр учиргүй их уурласандаа хамрынх нь угалз сарталзан байлаа. Цав цагаан цамц өмсөн, тод улаан зангиа зүүсэн тэр эрийг харваас үнэхээр төлөв түвшин хүн. Яалт ч үгүй орчин цагийн боловсролтой, хөрөнгө чинээтэй эр. Олны танил бизнесмэн болохоор нь хаа газар түүний зам нээлттэй байдаг. Ганц дургүй хүргэдэг газар нь төрийн хамгаалалтын албаныхан. Өдрийн цайндаа аятайхан таваг хоол идэж чаддаггүй тэд ямар албархуу байдаг гэж санана. Хуучин цагийн цэрэг ногоон хувцасны гол болцгоосон тэр хүмүүс нэг л их дүрдээ итгэцгээн бичиг баримтыг нь дурандах нь холгүй шалгадаг. Тэр бүхэнд нь түүний дургүй маш их хүрдэг байв. Бүгд л түүнийг хүндлэн бичиг баримтыг нь шалгах нь байтугай олигтойхон бөхөлзөхийг боддог байхад төрийн хамгаалалтын хэдэн шалдан банди нар арай л хормой хотыг нь ухахгүй. Тийм болохоор тэр төрийн хамгаалалтын залуучуудад үнэн голоосоо дургүй. Өөрийнх нь мэдлийн ажилтнууд байсан бол тэднийг улаан нүүрэн дундуур нь хэд байлгаж өгөөд аль хэдийн ажлаас нь халчих л байсан. Хамгаалалтынхны аз болж даанч түүний мэдэлд хамаардаггүй билээ. Энэ удаа ч ордны хамгаалагч түрүүч залуу түүний бичиг баримтыг маш нямбай үзсэнээ нэвтрэх бичигт нь гарын үсэг зурж өглөө. Тэрбээр болзсон цагаасаа хоцорно гэдгээс ухаан мэдрэлгүй болтлоо айж байлаа. Хэдэн зуун саяар нь унагах ашгийн тухай хөөцөлдөж явахад хүн болгон л саад болох янзтай. Ордны хамгаалалтын адгийн шаарнууд ч хүртэл алтан сайхан цаг мөчөөс нь хумсална шүү.

Уулзах хүн нь явчих вий гэхээс хаа яваагаа ч сэхээрэх сөхөөгүй яваа тэр эр хэдхэн харайгаад мөнөөх учралт хүнийхээ үүдэн дээр оччихов. Тэвдэж сандарсандаа хаалгыг нь тогших ухаан мэдрэл ч байсангүй. Цувныхаа хормойг намируулаад шууд л тавиад орчихов. Даргатай нь байнга уулздаг түүнийг туслах хүүхэн нь танимхайран толгой дохисныг ч анзаарсангүй. Түүний яарч тэвдсэнийх нь хэрэг энэ удаа гарчээ. Уулзах хүн нь гадуур хувцсаа ч тайлалгүй түүнийг урьж суулгаад сандал татан авч ойртон суув. Тэгснээ халааснаасаа янжуур гарган амандаа зуугаад яаралгүйхэн асаагаад утааг нь цагираглуулан хэдэнтээ үлээв. Хэсэг хором тэр чимээгүй байснаа “Бүх зүйлийг бид нар сайн төлөвлөчихсөн байгаа. Яг юу болохыг нь чи, бид хоёроос өөр хэн ч мэдэхгүй. Гол нь чи найдвартай хүмүүс олоо биз дээ? Ер дугуу орхиулж болохгүй. Гүйцээх л хэрэгтэй. Дараа нь гардагчдыгаа цэвэрлэ. Чамд энэ асуудал ерөөсөө хүрч болохгүй. Манайхан чамайг хэн гэдгийг мэдэхгүй байх ёстой. Тэгээд ч чи, бид хоёрын дунд л бүх зүйл үлдэнэ. Чамайг тендерт ялчих байх гэж би найдаж байсан. Чи тэрэнд одоо харамсаад байх хэрэггүй. Шинэ боломжийг бид гаргах гэж оролдож байна. Энэ боломжид гавьяа байгуулснаараа чи бидний хувьд алт шиг хүн болно. Чиний санаснаас ч илүү ашиг чамд олдох болно. Бүх

зүйлийг оньсого шиг л хийх хэрэгтэй. Өөрөөсөө өөр хэнд ч битгий итгэ. Хэрэв болвол, шаардлагатай гэж үзвэл гардагчдыгаа цэвэрлээд зогсохгүй зохион байгуулагчийг нь ч цэвэрлэ. Эхний ээлжинд чиний ажилд хэрэг болох хэдэн төгрөг дансанд чинь оруулчихъя. Бүх юм сайхан хийгдсэний хойно үлдэгдлийг оруулна.

Хаана, юу ч ярьж болохгүй. Надтай утсаар ч ярих хэрэггүй. Зөвхөн найдвартайгаар нь хийснийхээ дараа холбоо бариарай. Саарал ордон чиний талд байгаа. Ордныхон дотор тэр асуудлыг дуусгахыг хүлээж байгаа хүмүүс нэлээд байгаа. Тийм болохоор юун дээр ч санаа битгий зов. Тав дахь өдрийг сонгодог чинь сайн байна. Бид нэг дэх өдөр хүртэл хангалттай цаг хожно. Цагдаа, аюулаас хамгаалахад ч манай хүмүүс ажиллаж байгаа. Гэлээ гээд тайвширч болохгүй. Гол нь ул мөргүй хийж, зуун жилээр ч яригдах оньсого болгох хэрэгтэй. Үүнийг л бод. “Дараагийнх нь Бат-Үүл” гэж заавал хэлүүл. Тэр нь бидэнд мөрөө төөрүүлэх бодлогын хувьд маш чухал байна. Миний хэлэх гэсэн юм энэ байна. Чамд яриа юу байна. Цайны цаг дуусахаас өмнө аяга хоол олж иддэг юм уу даа, би” хэмээн нэгэн амиар үгээ зөөн шивнэх нь холгүй ярьсанаа сандлынхаа түшлэгийг налан гэдийв. Буянтай инээмсэглэл нүүрэндээ тодруулсан хэрнээ цаанаа л нэг жийрхмээр царайлдаг энэ албан тушаалтныг монголчууд сайн мэднэ. Үргэлжид ямар нэгэн албан тушаалтны сандал дээр сууж байдаг энэ албан тушаалтан улс төрийн аль ч хүчинд тал алддаггүй хүн. Түүнийг хэн ч, эрхэм түшээд ч, яамдын сайд ч, газрын дарга нар ч ямархуу янзын хор найруулдгийг нь үл мэднэ. Заримдаа түүний хоронд хордсон хүмүүс өөрийг нь хэн нэгэн чадсан тухай түүнд ирж хорсонгүй ярих нь энүүхэнд. Тэр бүхнийг мань эр чив чимээгүй “Өө, тийм үү? За, за” хэмээн юу ч болоогүй юм шиг сонсч чаддаг байлаа.

Увайгүй, хүний үнэргүй байдлаараа мөлхөө өвс шиг хүн хүнд очоод наалдаж чадсан түүнийг эрх баригчдыг ч, сөрөг хүчний нөлөө бүхий нөхдүүдийг ч ер нь улс төрийн хүрээнийхэнг бүгдийг нь атгачихсан гэхэд хилсдэхгүй. Аалзны тор мэт хаа сайгүй хэрсэн түүний хор найруулгын сүлжээг зад татаж чадах хүн өнөөхөндөө Монголд хаана ч алга юм. Цусанд нь дотор хүний бөөм нэвт шингэсэн, царайд нь эрдэм мэдлэгтэйн төрх илэрсэн тэр хүнийг “Цагаан харх” хэмээх улс төр, гэмт хэргийн бүлэглэлийнхэн “Ордны тул” хэмээн нэрийдэн хамгаалалтандаа байлгадаг гэж нэг ч монгол хүн мэдэхгүй байх. Мэдэх ч бүү хэл зүүдлээ ч үгүй. Эдийн засаг, хууль, цагдаагийн албадад бууны нохдоо зай завсаргүй тавьж орхисон “Цагаан харх” нийгэмлэгийнхэн түүнийг нүдний цөцгий мэт хайрлаж, хамгаалах, хэрэгтэй үед хэдэн зуун хүний амиар ч хамаагүй сольж авах төлөвлөгөөтэй байдаг юм. Яагаад гэвэл “Цагаан харх”-ынхан түүнийг алдана гэдэг хороо цэрэг мэргэн буудагчаа, хөлбөмбөгийн баг гол довтлогчоо алдахтай яг адилхан билээ. Албан тушаалтан эр бизнесмэнийг хэсэг зуур таг дуугүй харж байснаа “За, гарах уу? Чамд яриа байхгүй бол одоо өөр юу байхав дээ” гэв. Мөнгөний төлөө хоёр нүдээ ухаад ч өгөхөөс буцахгүй бизнесмэн эрийг тэр юу бодож байгааг сайн мэдэж байлаа. Хоолыг нь ахиухан өгөөд байвал дуу нь чангаран хот, хороогоо хавь орчныхноосоо харамлан тасчих нь холгүй байдаг тэжээвэр нохой шиг тэр эрд мөнгөний сургаар хүн алах зэрэг бол юу ч биш гэдгийг тэрбээр сайн тооцоолсон.

Түүний тэрхүү юу ч хийхээс буцахгүй зоримог, түрэмгий чанарыг олж хараад албан тушаалтан эр өөрийнхөө гар, хөл болгож авсан билээ. Бизнесмэн албан тушаалтан эрийн асуултад хариу болгон “Яаж ч бодсон чамгүй их мөнгө хаяж таарах нь тодорхой. Та нар дансанд мөнгө хийчихсэн бол би юу гэхэв. Ярьснаараа л бүгдийг дуусгачихъя” гээд

суудлаасаа босов. Албан тушаалтан эр түүнийг яг л ингэж хэлэхийг мэдэж байсан ажээ. Тэрбээр “Урьдчилгаа хэдэн төгрөг өгөхгүй бол тэр хөдөлж өгөхгүй хүн. Мөнгө байвал юу ч харин хийчихнэ. Осолтой хүн дээ. Бүх зүйл дууссаны дараа эвгүйтгээд ирвэл “Цагаан харх”-ынханд захиалга өгчихнө. За даа, ер нь ч аль тохиолдолд тэгчихсэн нь дээр байх” хэмээн бодсоноо, “За, гарцгаая” гэж нүүрэндээ нэг их худлаа инээмсэглэл тодруулав. Бүх л үеийн турш монголчуудын хувь заяагаар тоглогчдын хуйвалдаан орогногчдын үүр болсон саарал ордны хойд хаалгаар төд удалгүй мөнөөх бизнесмэн эр цуваа намируулсаар гарч одлоо. Юун түүрүүн тэрбээр банк орж дансаа шалгахыг бодож байв. “Мөнхийн ашиг сонирхол гэж байдгаас мөнхийн нөхөрлөл гэж байдаггүй” гэдэг үгийг байнга хэлэх дуртай тэр эрд хэдэн зуун саяар яригдах ашгийн төлөө нэг хүний амь насыг хөнөөхийг зохион байгуулах явдал бол даанч амархан ажил байлаа.

ГУРАВ. ГАНЦААРДАЛ

Зоригийг өглөө орцноосоо гарахад үүдэн дээр нь нэгэн золбин гөлөг сүүлээ хөдөлгөн гаслан угтдаг болоод тав, зургаан хоног болов. Эхэндээ тэрбээр гөлгийг анзаардаггүй байснаа сүүлийн хоёр удаад нь маш сүрхий анзаарлаа. Хоол горьдоод ч тэгж байгаа юм уу, тэр гөлөг нэг л их будант нүдээр өөрийг нь ширтэхийг Зориг хараад “Энэ муу амьтан ингэж явах ч гэж дээ” хэмээн өрөвдсөн юм. Тэгэхдээ л тэр гөлөг учирлаад ч байгаа юм уу, уйтгарлаад ч байгаа юм уу, ер бусын сонин харцтай байхыг Зориг харсныхаа дараа нэг л зүйлийн тухай маш их боддог болсон билээ. Тэр нь юу вэ гэхээр нийгмийн хамгаалал. Яг л энэ золбин гөлөг шиг уйтай нүдээр монголчуудын олонхи хардагийг Зориг мэднэ. 1990 оны хавар түүний үгийг бишрэн дагаж, сайн сайхан ирээдүйн төлөө амь амьдралаа золиослохоос ч буцахгүй байсан тэр олон хүмүүсийн ихэнх нь орчин тойрноо даанч дээ гэмээр будант нүдээр хардаг болсныг тэрбээр сайн мэднэ. Тэр үед тэдгээр хүмүүс юу хүсч, юу мөрөөдөж байсан нь тодорхой. Ийм гунигт, ийм зовлонт амьдрал хүсээгүй гэдэг нь лавтай. Энэ тухай бодохоор Зоригт хүнд байдаг билээ. Тэр өөрөө бүхний өмнө буруутай юм шиг л болчихдог юм. Тэгээд л тэрбээр зовлонт гөлөгний нүдийг харснаасаа хойш нийгмийн хамгааллын талаар өмнө нь бодоогүйгээр их боддог болсон юм. Бээлийнхэн чинээ тэр гөлөгнд тэжээх эзэн дутаж байгаа юм шиг монголчуудад өнөөдөр төрийн ивээл, хайр дутаж байгаа юм шиг түүнд санагдсан. Тийм болохоор л тэр нийгмийн хамгааллыг яаж Монгол оронд бодитой зүйл болгох вэ гэж олон шөнө нойроо хугаслан бодсон юм. Тэгж бодох бүхэнд нь шударга ёсны тухай ойлголт тархи толгойг нь зай завсаргүй зовоох болсон билээ. Энэ тухай тэрбээр зарим нөлөө бүхий албан тушаалтнуудтай санаа бодлоо солилцох гэж үзээд даанч дээ гэмээр урам нь хугарсан юм.

Үнэндээ Монголын нэр нөлөө бүхий улс төрчид дэндүү жижигхэн зүйлийн төлөө, албан тушаалын төлөө, эрх мэдлийн төлөө, нам, бүлгийнхээ эрх ашгийн төлөө л ажилладаг болохоос биш олон нийтийн төлөө гэсэн өчүүхэн ч сэтгэлгүй байдаг юм байна гэдгийг тэр мэдээд учиргүй их ганцаардаж байгаагаа ойлгосон юм. Тэгээд ч тэр зориудаар тэдгээр хүмүүст санаагаа ойлгуулах гэж “Аливаа улс төрч хүний хувьд нэгдүгээрт, улс, орны эрх ашиг хоёрдугаарт, нам бүлгийн эрх ашиг гуравдугаарт, хувийн эрх ашиг нь байх ёстой” хэмээн хэлж ч үзсэн. Түүний үгийг хүлээж авч байгаа хүн хүний урманд нэг ч байгаагүй.

Монголын улс төрийн амьдрал өнгөн дээрээ хоёр том хүчний өрсөлдөөн дунд явагдаж байгаа юм шиг байвч хэрэг дээрээ цөөн хэдэн хүний хуйвалдаанаар шийдвэрлэгдэж байгааг Зориг мэдсэнээсээ хойш “Энэ хуйвалдааны сүлжээг л задлах хэрэгтэй. Тэгвэл бүх зүйл өөр болох юм байна. Энэ янзаараа бол Монгол улс мафийн сүлжээнд автах нь гарцаагүй боллоо. 1990 онд бид өөр зүйлийн тухай ярьж байсан. Тэр үед ярьж байсан зүйл маань маш өөр зүйл болон хувирчээ. Бид ардчиллыг Монгол оронд авчирсан нь үнэн. Гэхдээ улс төрийн хүчнүүдийн хуйвалдаан эдийн засаг, цагдаагийн нууц сүлжээ бий болгох гэж авчраагүй. Одоо цаг үе биднээс өөр зүйл шаардаж байна. Харамсалтай нь, ойлгохгүй байгаадаа биш, дургүй байгаадаа энэ тухай ярихгүй байна. Ардчилсан хүчний Засгийн газруудыг ойр ойрхон унагаад байгаа нь шударга ёсны төлөө биш, эрх мэдлийн төлөө л хийгдэж байна. Энхсайханы Засгийн газар ч, Элбэгдоржийн Засгийн газар ч муудаа унаагүй.

Зөвхөн эрх мэдлийн л өрсөлдөөн. Дараагийн сонгуульд ялах хүсэлдээ автсан Ху намынхан л ямар ч тохиолдолд эрх баригчдын Засгийн газрыг унагахын төлөө саналаа өгөх нь тодорхой. Эрх баригчид болохоороо бүлэглэлд хуваагдан бие биенийхээ эсрэг санал өгөөд байгаа нь ойлгомжгүй юм. Мэдээж үүний цаана зөвхөн эрх мэдлийн төлөөх шуналын малгайг нь соливч толгой нь хэвээрээ үлдээд байгаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад нэр дэвшигчдийг тодорхой бус шалтгаанаар унагаад байгаа нь ойлгомжгүй юм. Эцсийн дүнд эрх мэдэлтнүүд биш ард түмэн л хохирч байна” хэмээн дотроо хий л санааширдаг болсон билээ. Зориг энэ талаар зарим нөхөдтэй ч ярьсан. Гэвч тэдэнд хэн нэгэн өөрийн талын хүнээ Ерөнхий сайд болгох, дараа нь бусад албан тушаалын бялууг хэрхэн хуваах нь сонин байхаас биш түүний ярьж буй, хүсч буй шударга ёс, нийгмийн хамгаалал огтхон ч падгүй байдаг байв. Зоригийг энэ өглөө гэрээсээ гарахад нь нөгөө муу золбин гөлөг гунигт нүдээр харсаар л угтав. Тэрбээр халаасаа хий дэмий л тэмтэрснээ “Энэ муу гөлгөнд цадтал нь хоол өгье байз. Өнөөдөр амжихгүй нь дээ. Маргааш өглөө л санаж байгаад хооллохоос” гэж амандаа үглэснээ ажил руугаа хавтсаа сугавчлан алхлаа. Тийн явах замдаа “Алийн болгон бид ингэж хоорондоо өстэй юм шиг уралцаж, хий дэмий цагаа өнгөрөөж байхав. Гол нь зөвшилцье. Зөвшилцлөөр л бүхнийг шийднэ шүү дээ. Маргалдаж сөргөлдсөнөөс үр дүн гарахгүй. Намын улс төрийн зөвлөл дээр энэ тухай ярих л хэрэгтэй. “Нэг удаа ч атугай өөрсдийн эрх ашгийг нэгдүгээрт тавья” гэж хэлье” хэмээн бодож байлаа. Зөрөн өнгөрч буй хүн бүхэн л мөнөөх зовлонт гөлөг мэт аврал эрсэн нүдээр түүнийг харах шиг болоход түүнд эвгүйрхэх сэтгэл өөрийн эрхгүй төрж байв.

ДӨРӨВ. ЭЗЭН

Зуун айлын гэр хороолол дундах нэг давхар шөнийн цэнгээний газрын булангийн нэгэн нууц өрөөнд тавь гаруй насны хоёр өвгөжөөр эр виски хүртэн мөсөөр даруулан шимж, янжуур шившин суусаар даруй хоёр цаг шахам болов. Намхандуу нуруутай, халзан толгойтой бүдүүн эр нь үе үехэн цагаа хяламхийн харна. Тэрбээр хэн нэгнийг хүлээж, цөхөж ядаж байгаа янзтай байлаа. Харин өндөрдүү нуруутай, тас хар өмсгөлтэй хэрнээ

був буурал толгойтой, нүдний шилтэй нөгөө эр нь тасралтгүй цавчлах хурц нүдээр шилнийхээ цаанаас сэмхэн ширтэнэ. Халзан толгойт намхан эр хундагатай вискигээ нэгэн амиар татсанаа янжуур сугалан авч имрээд “Цаадахь чинь яагаад сураг ажиггүй болчихов оо? Иймээ, тиймээ юм болчихоогүй л байлтай” хэмээн амандаа гүвтнэв. Нүдний шилт түүний үгийг сонсоогүй мэт чив чимээгүй байснаа “Хашир хүн баараггүй юм хийх гээд л удаад байж магадгүй. Түүнээс биш хий гишгэнэ гэж байхгүй л дээ. Гай газар дороос гэгчээр шальдар бульдар ажил гарчихаад цагийг нь уяад байж магадгүй. Одоо нэг их удахгүй ирнэ биз. Хоол болтол шийр зугаа байна” гээд хоёр хундагандаа дахин хундагалснаа тавагтай мөснөөс хэд хэдийг хавчуураар авч вискигээ хундага руугаа яаралгүйхэн хийлээ. Дөчин градусын часхийсэн виски тэмээний хорголын чинээ мөснүүдийг тэр дор нь хайлуулан бужигнатал уусгахыг халзан толгойт эр гөлрөн харснаа “Тийм ч байлгүй дээ” гэж дуулах төдий гөвтнөлөө. Энэ хоёр хижээл эрхмийг харсан хэн ч гэсэн тохитой томоотой хүмүүс бие биендээ цаг гарган ажил төрөл ярилцангаа амарч тухалж сууна даа гэж бодохоос биш хэрэг дээрээ Монголын нийгмийн амьдралд далдаас хуруу, гараа дүрэн зохицуулж байдаг “Цагаан харх” нийгэмлэгийн нөлөө бүхий эрхмүүд ээлжит олзоо хуваах гэж адгаж байгааг яахин мэдэх билээ.



Хуучин цагийн үед улс төрийн өндөр албан тушаал эрхэлж байсан энэ хоёр хүн гадны тусгай албад, гудамжны бүлэглэлтэй холбоотой ажилладаг бөгөөд алдагдсан эрх мэдлээ хадгалж үлдэхийн төлөө 1990 оны эхээр “Цагаан харх” хэмээгч нууц бүлэглэлийг байгуулсан юм. Анхандаа тэд хэрэг бишидвэл Монголын засгийн эрхийг хүчээр ч

болтугай буцааж авна гэж “Цагаан харх” бүлэглэлийнхээ бодлогыг тодорхойлж байсан юм. Нийгмийн гэнэт задрал үүсэн байр суурь нь хүчтэй ганхахад цаг үеийн шаардлагаар ч гэдэг юм уу эсвэл тохироо бүрдсэн болохоор ч гэдэг юм уу зайлшгүй л тэд арга буюу эрх мэдэл, байр суурийн төлөө дугуй, дугуйгаа олж нөхөрлөсөн. Хоёр гурван эрх мэдэлтний үүсгэн байгуулсан “Цагаан харх” бүлэглэл байгуулагдсан өдрөөсөө эхлэн хүрээгээ хүчтэй тэлсэн гэхэд хилсдэхгүй. Гол төлөв хуучны албан тушаалтнуудаас бүрдсэн уг бүлэглэл гол зорилгоо Монголын эдийн засгийн бодлого руу чиглүүлсэн. Тэдэнд УИХ-ын гишүүн болох, яамдын сайд, газрын дарга болох бол сонин биш байсан. Хамгийн гол нь эдийн засаг, мөнгөний бодлогод нь үл үзэгдэгч гараа дүрж байх нь чухал байлаа. Тийм ч болохоор тэд юу ч үгүй гудамжинд гарах болчихвол хүч хэрэглэх тухай төлөвлөж байсан юм. Гэтэл тэднийг даанч дээ гэмээр аз түшсэн. Монголын шинэ Засгийн газрууд анхныхаа өдрөөсөө л эхлэн эдийн засгийнхаа тэр тусмаа мөнгөний бодлогод ямар ч хяналт зохицуулалтгүй хандаж эхэлсэн болохоор газраар нэг цацсан алтыг шуудайлж авах шиг л сул мөнгөнүүд тэдний өвөр түрийд нь орж ирсэн. Тэр сул мөнгийг тэд харин өөрсдийн хүмүүсийн гар дээр бодлоготойгоор зохицуулж эхэлсэн билээ. Ямар ч барьцаа баталгаагүй урсч буй банкны зээлүүд тэдний далд Засгийн газрын дансанд цаг, минут тутамд орж эргээд гарахдаа харин хатуу, чанга, зохион байгуулалттайгаар гарч эхэлсэн юм.

Дээр нь бас хараа хяналтгүй өмч хувьчлалууд тэдний сан хөмрөгийг үерийн ус шиг л арвижуулсан. Нэг ёсондоо Монголын эдийн засгийн тодорхой хэсгийг эзэмших, эдийн засгийн бодлогод нь байр сууриа үргэлж хадгалж байх сонирхолтой байсан “Цагаан харх” бүлэглэлийнхэнд эрх мэдлийн төлөө хүч хэрэглэх ямар ч шаардлага үгүй болж, зөвхөн олсон олзоо тасралтгүй өсгөх, эдийн засгийн байр сууриа хэзээ ч алдахгүй байх нь үндсэн зорилго нь болсон юм. Энэ л зорилго дээрээ тулгуурлан тэд Монголд хууль бус арилжаа эрхлэн, улс төр, тусгай албад, цагдаагийн эрхтэн дархтануудын дунд өөрийн хүмүүсээ сэмхнээр шургуулж эхэлсэн билээ. Тийм хүмүүсгүйгээр “Цагаан харх” яагаад ч оршин тогтнохгүй нь тодорхой. “Цагаан харх” тэднээр дамжуулан арьсаа хамгаалж, тэднийг хараа хяналт, хамгаалалтандаа байлган улс төр, эдийн засгийн ашиг сонирхлоо хадгалж байдаг юм. Хэрвээ Монгол Улсын Засгийн газар тэднийг илрүүлэн нууц сүлжээг нь задлахыг оролдвол тэд хүнд байдалд орох билээ. “Цагаан харх”-ынхны хамгийн болгоомжилдог зүйл нь тэр. Мөн тэдний далд эдийн засгийн эргэлт нь хууль бус наймаа байдаг болохоор яалт ч үгүй тэд Азийн гэмт хэргийн бүлэглэлүүдтэй холбогдсон. Ялангуяа Хятадын гудамжны бүлэглэлүүд тэдний гол түнш байдаг. Дэлхийн цагдаа гэж нэрлэгддэг Америкийг ч донсолгодог Хятадын гудамжны бүлэглэлтэй холбоотой байх нь “Цагаан харх”-д оршин тогтнох нэг үндэс нь болдог юм. Хятадын гудамжны бүлэглэл Монголд хэдий чинээ байр сууриа эзэлнэ төдий чинээ “Цагаан харх” хүчтэй байх нь тодорхой билээ. Өнөөхөндөө Монголын эдийн засгийн тодорхой хувийг эзэлж буй “Цагаан харх” цаашид энэ янзаараа хүрээгээ тэлвэл ойрын хэдхэн жилд л бүх мөнгөний эргэлтийн тал хувийг мэдэлдээ авахаар байгаа.

Хэрвээ тэгж чадвал Монгол улс “Цагаан харх”-ынхны мэдэлд орлоо л гэсэн үг. Тэднийг тэгж хүчирхэгжихээс нь өмнө хэн нэгэн нөлөө бүхий хүн засгийн эрхэнд гарчихаад тэдний эсрэг шударгаар ажиллавал тэд хэсэгтээ л эвгүй байдалд орно. Бүрмөсөн устдаггүй юм аа гэхэд одоогийн эрх мэдлээ алдана. Гол нь Монголын төрийн нөлөө бүхий хүмүүсийн хүрээнд хийсэн сүлжээ нь задарна гэсэн үг. Тийм сүлжээг дахин байгуулна гэдэг бол санашгүй хэрэг юм. Одоо бол 1990 он биш. Монголчууд гэнэн, цагаан зангаа

багагүй гэсэн. Яснаасаа үндсэрхэг үзэлтэй монголчууд алхам бүрт нь тэдэнд саад хийх нь тодорхой. Хүлээж суугаа мөнөөх хоёр эрд цаг хугацаа чамгүй удаан өнгөрч байв. Тэр хоёр 700 грамм шотланд вискийг бараг ёроолд нь хүртэл уужээ. Барагцаалбал тэд гурван цаг гаруй хүлээжээ. Намхан нуруут халзан эр тэсвэр алдаж байгаа бололтой цаг руугаа хяламхийснээ “Яалт ч үгүй л нэг ажил гарч дээ” гээд буурал толгойт руугаа хариу хүлээсэн янзтайгаар харлаа. Буурал толгойт “Нэг юм болох нь болж. Жаахан хүлээж байгаад болохгүй бол холбоо барих гээд оролдоод үзэхээс” хэмээн амаа даран эвшээлээ. Хуучин цагийн НАХЯ-нд залуу зандан насандаа ажиллаж байгаад дээд газрын шийдвэрээр суга татагдан Монголын улс төрийн томоохон өндөрлөгт хүрч очсон энэ буурал толгойт егзэр эрийг өөрсөдтэй нь нэг зиндаанд сууж ярилцчихаад ачир дээрээ “Цагаан харх”-ын бүх үйл ажиллагааг далдаас удирдаж байдгийг “Цагаан харх”-ынхан тэр чигээрээ мэддэггүй. Тэр ч бүү хэл, үргэлжид л хамт байж үйл ажиллагааг нь гардан зохион байгуулалцдаг хажууд нь сууж буй намхан нуруут, халзан толгойт эр ч огт төсөөлөөгүй билээ.

Анх “Цагаан харх”-ыг байгуулахад буурал толгойт эр бусаддаа дотор газрын бололтой нэгэн зальжин байрын өвгөнийг дагуулан ирээд “Манай “Цагаан харх” бүлэглэлийн тэргүүн. Хятадад нөлөө бүхий хүн. Бидний үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Бидэнд байнга тусална” хэмээн танилцуулсан юм. Үнэндээ тэр нь “Цагаан харх”-ын нууц эзэн биш Хятадын бага гарын буруу гарын наймаачин гэдгийг буурал толгойтоос өөр хэн ч мэдэхгүй байсан юм. Буурал толгойт “Цагаан харх”-ыг тэгж анх байгуулчихаад мөнөөх хятадыгаа буцаагаад нутаг руу нь явуулчихсан. Тэгэхдээ Хятадын тусгай албадад өөрийнхөө гарын хүмүүсээр дамжуулан тоглоомон хятад эзнийхээ буруу гарын наймааг илчлэн бариулаад үгүй хийлгэчихсэнийг нь чөтгөр ч анзаараагүй билээ. Түүнээс хойш буурал толгойт бусаддаа далд эзнийхээ бодлого, үйл ажиллагааг дамжуулагч болон харагдаж, үнэн нүүр царайгаа хэзээ ч илрэхгүйгээр нууж чадсан юм. Энэ удаа ч тэрбээр намхан нуруут, халзан толгойт хамт өөрийн төлөөний хүнээр дамжуулан чамгүй их спирт Хятадын хилээр оруулж ирчихээд байгаа бөгөөд гаалийн газарт ажилладаг нөлөө бүхий гишүүнээрээ зуучлуулан ямар ч хал балгүй оруулж ирсэн тэр их спиртээ мөн л өөрийн гарын цагдаагийн нэгэн офицерээр нэр хүнд бүхий компанид заруулчихаад хэдий хэмжээний ашиг унасныг нь тооцож авахаар хүлээж суугаа нь энэ юм. Буурал толгойт, халзан толгойт хоёрыг дахин цаг шахуу хүлээлгэж байж учраат хүн нь үл ялиг инээмсэглэл тодруулан уучлалт гуйсаар орж ирэхэд өнөөх хоёрын нүд илт сэргээд явчихав. Ажил төрөл нь харваас бүтсэн янзтай байх нь тодорхой тул буурал толгойт баярын хундага өргөхөөр дахин нэг шил виски захиалахаар суудлаасаа бослоо.

ТАВ. ТОРГОНЫ ЗАМ

Тагнуулын төв газрын ажилтан ахлах дэслэгч Цацралыг сейфээ лацдаад гарах гэж ширээн дээрх зүйлээ янзалж байхад нь гэнэт утас нь дуугарав. Бичиг цаастай ноцолдоод шөнийн 02 цаг хүртэл харихаа мартан суусан тэрбээр цагаа харснаа “Оройтлоо гээд авгай л утасдаж байх шиг байна. Ажил хийлгэхгүй оройноос хойш утасдаад чих амраасангүй. Энэ хүүхнүүд ер нь яршигтай юм аа. Заримдаа ч авгайгүй байвал дээр юм шиг байна” хэмээн үглэснээ утсаа автал авгайн биш шал өөр жингэнэсэн дуутай эрэгтэй хүн “Цацрал уу? Чи намайг танихгүй байгаа биз дээ? Таних ч албагүй л дээ. Би чамайг өрөөндөө сууж байгааг авгайгаас чинь мэдээд утсыг чинь авлаа. Тэгээд утасдаж байна. Чамд эр хүний хувьд нөхөрсгөөр хэлэхэд дэмий юмны хойноос хөөцөлдөх дэмий л байдаг юм. Урт хэл хүзүү

орооно гэдэг үг байдаг даа. Чи галзуу солиотой юм шиг хүний үгэнд ороод шал дэмий зүйл хийх гээгүй биз дээ? Ер нь үнэн байлаа ч гэсэн холхон байх нь л уул нь чамд хэрэгтэй дээ. Залуу хүн элдэв юмтай орооцолдож байснаас авгай, хүүхэдтэйгээ орой үдэш хамтдаа байх нь л дээр байдаг юм даа. Авгай чинь юу ч хийж байгаа юм билээ. Ухаантай хүн юм бол бодоод үзэхгүй юу” гэснээ утсаа тавьчихав. Цацрал хэн, юу ярьсныг ч ойлгожгүй хэсэг алмайрч байснаа сэхээ авч опертив жижүүр рүүгээ дотуур утсаар “Сая над руу тав, зургаан минутын өмнө нэг хүн заналхийлж ярилаа. Хаанаас ярьсныг нь мэдэх хэрэгтэй байна. Энэ тухай мэдээлээрэй” хэмээн өгүүлснээ гадуур утсаараа гэр рүүгээ утасдав. Эхнэр нь утасны цаанаас шал нойрмог дуугаар дуугарах агаад “Чи хэнд, юун хүнд миний ажлын утсыг өгсөн юм бэ?” гэж асуухад нь “Юун хүн, юу яриад байгаа юм бэ? Надтай хэн ч яриагүй ш дээ. Манайх руу өнөө орой хэн ч яриагүй. Өөрөө ирэхгүй, тэгээд хүн унтуулахгүй шал балай юм” гэж үглээд залхуутайгаар эвшээлгэх нь сонстов.

Цацрал “Би одоохон. Ингээд очлоо. Хүн хаалга үүд тогшвол над руу утасдаарай, нойрмоглож байгаад битгий онгойлгочихоорой” гээд утсаа тавив. Тэгснээ ширээн дээрээ суугаад хэн, юуны тухай ярьсан байж болохов гэж шанаа тулан бодолхийлэв. “Энэ бол ямар ч байсан заналхийлэл л байна. Ойрд би хүнээр заналхийлгэх юу билээ. Зургаа, долоон сард би ажлаасаа чөлөө авсан, найман сарын сүүлээс есөн сарын аравд хүртэл залгуулаад амралтаа авсан. Тэгэхлээр би сүүлийн үед ямар нэгэн хүн амьтны дургүй хүргэх юм хийгээгүй гэсэн үг. Урьд өмний юм байж болох юм. Тэгэхдээ энэ хүн чинь галзуу солиотой хүний үгэнд ороод юу хийх гээд байна гэл үү?” гэх зэргээр элдвийг бодож байснаа юу хэлж байгааг нь саналаа. Дөрөв хоногийн өмнө өөрийгөө улс төрийн төлөө тэмцэгч, шударга иргэн гэж танилцуулсан нэгэн залуу түүнтэй гудамжинд отоож байж уулзаад “Төлөөлөгч өө, би танд нэг чухал мэдээлэл өгөх гэсэн юм. Цаана чинь нэгэн нэртэй улс төрчийг хүмүүс мөнгө өгөөд хөлсний алуурчнаар алуулах гэж байна” хэмээн ярьсан билээ. Цацрал тэр үгийг нь огт тоогоогүй хэрнээ дэмий байхаар дээш нь мэдэгдчихье гэж мэдээлэл бэлдсэнээ ямар ч судалгаагүй шал дэмий юм бичиж даргадаа загнуулахаа больё гэж бодоод орхичихсон билээ. Шал дэмий шахуу тэр яриа гудамжинд тав, зургаахан минут болоод л өнгөрсөн. Тэгтэл тэр яриаг чухал зүйл болгон түүнийг хэн нэгэн шөнийн 02 цагт ажил дээрээ байгааг мэдэн заналхийлж утасдаж байдаг. Үүнд ямар нэгэн зүйл байна. Яаж ч байсан түүнтэй уулзсан тэмцэгч гэж өөртөө итгэсэн тэр нэгэн залуу л Цацралыг шөнө ажил дээрээ байгааг хүнээс олж мэдээд утасдана гэдэг түүхэнд байхгүй. Тэгэхлээр үүний цаана хэн нэгэн урт гартан байна даа гэж Цацрал бодлоо.

Тэгээд тэр урт гартан түүнийг гэртээ байхгүй байгааг чинь ч, эхнэр чинь ганцаараа байгаа гэдгийг чинь ч мэдэж байна шүү гэдгээ тойруу замаар хэлсэн болж таарч байлаа. Түүнээс биш эхнэртэй нь яриагүй байж тэр заналхийлэгч юу гэж эхнэртэй чинь ярилаа хэмээн барим тавим хэлэхэв дээ. Тодорхой шууд чиглэсэн заналхийлэл хийж байгаа нь тэр юм. Иймэрхүү дам заналхийллийг мэргэжлийнхэн сэтгэлзүйн дайн гэж өгүүлдэг билээ. Цацрал ширээнийхээ нүдэнд байгаа тамхинаасаа авч шившээд тэр урт гартан хэн байж болох талаар толгойгоо гашилгаж гарлаа. Тэгж бодож байхад нь түүнд гурван жилийн өмнө нэгэн нөлөө бүхий туслахаас нь Хятадаас Монгол руу чиглэсэн “Торгоны зам” гэж хууль бус наймааны дардан зам байдаг тухай зарим нөлөө бүхий Хятадын наймаачид ярьдаг тухай өгсөн мэдээ санаанд нь орлоо. Туслахынх нь ярьснаар уг торгон зам гээчийн ар талд эрх баригч, сөрөг хүчний томоохон хүмүүс байдаг бөгөөд тэд хил, гаалийнхныг албан тушаалаараа далайлган хууль бус бараагаа оруулж ирдэг болж таарсан юм. Тэрхүүн

торгон замын ард туслахынх нь мэдэж байгаагаар саарал ордонд алба хашдаг нэр бүхий цөөн бус хүн байж таарахаар болсон бөгөөд тэд уг сүлжээгээ, хуйвалдаанаа хадгалж үлдэхийн тулд улс төрийн ямар ч захиалгат аллага хийхээс сийхгүй нь тодорхой гэсэн юм.

Цацрал туслахынхаа мэдээллийн араас явж үзсэн. Тэглээ гээд түүнд ямар ч үр дүн, ашиг олдоогүй. Харин Хүннүгийн үед Таримын хотгороор холбогдсон морьтон ардууд дорнын торго дурданг өрнө рүү зөөдөг байсан бөгөөд уг замыг нь түүхэнд “Торгоны зам” гэж нэрлэгддэг болсон тухай олж мэдсэн юм. Тухайн үед тэрхүү “Торгоны зам” нь Хятадын торго дурданг зарж борлуулахад маш том үүрэг гүйцэтгэдэг байсан гэдгийг Цацрал уншаад “Монголын Торгоны зам гэж нэрлээд байгаа энэ зам ч үнэхээр байдаг бол Хятадын хууль бус наймаачдын барааг их л борлуулж байгаа юм байна даа” гэж бодоод л өнгөрсөн билээ. Гурван жилийн өмнө туслахынх нь ярьж байсан тэр “Торгоны зам” дөрөв хоногийн өмнө мэдээлэл өгсөн тэр нэгэн эрийн мэдээлэл хоёрт үл үзэгдэх нарийн үл үзэгдэх холбоо байж болох юм шиг Цацралд санагдаад явчихав. Цацрал тийн толгойгоо гашилгаж, бодолхийлэн сууж байснаа цуваа амч өмсөөд өрөөнөөсөө гарлаа. Гарахдаа тэрээр оператив жижүүртээ “Түрүүн над руу утасдсан хүнийг хаанаас утасдсаныг заавал олох ёстой гэдгийг мэдээнд тусгаарай” гэж хэлчихээд гэр рүүгээ яаран явав.

ЗУРГАА. ЭРГЭЛЗЭЭ

Зоригийг өдөр ажлынхаа өрөөнд сууж байтал намынх нь эрх мэдэл бүхий нэгэн эрхэм утасдаад “Зоригоо, чамайг би Ерөнхий сайдад дэвшүүлэх хүсэлтэй байна. Чи татгалзахгүй биз дээ? Аль ч талаас нь бодсон одоо чамаас өөр Ерөнхий сайдад дэвшчихээр хүн манай намд байхгүй юм шиг байна. Цаадуул чинь ямар бодол санаатай байгааг би мэдэхгүй. Гэхдээ нөхцөл байдал ийм байгаа юм чинь бүгд л дэмжиж таарах байх. Ерөнхийлөгчид ямар бодол шүгэлчихээд санаанд нь таарах хүн олдохгүй байгаа юм бол? Ёстой бүү мэд. Д.Ганболд, Г.Ганхуяг, Э.Бат-Үүл нарыг “Голомт банк”-ны холбогдолтой асуудлаар гэсэн шалтаг заагаад гаргасангүй. Р.Амаржаргал олонхийн санал авч чадсангүй. Уул нь яршиг цаашаа, анхнаасаа л Да.Ганболдыг Ерөнхийлөгч хүлээгээд авчихсан бол ингэж заваарахгүй амар байхгүй юу. Да.Ганболд гарлаа гээд Засгийн газар түүний өмч болчихгүй л баймаар юм. Хоёрын хоёр улс төрийн хүчний бүрдүүлж байгаа Засгийн газарт дотоод хяналт байж таарна биз дээ. Хэрвээ чамайг дэвшвэл Ерөнхийлөгч хүлээж авч ч байж мэдэх юм, авахгүй ч байж мэдэх юм. Тэгэхдээ миний бодож байгаагаар чи л дэвшчихвэл болчих юм шиг санагдаад байх юм” хэмээн ярьсан билээ. Зориг түүнийг тийм санал тавьсанд баярласнаа илэрхийлээд “Энэ талаар би бодох хэрэгтэй байх. Бас бусад хүмүүстэй ч зөвшилцөх хэрэгтэй байх” гэсэн хариултыг өгсөн юм. Зориг энэ тухай бодоогүй биш бодож байсан. Хэрвээ би Ерөнхий сайд байсан бол нэлээн хариуцлагатай хүнд ачааг үүрч таарна. Тийм болохоор сэтгэлийн хөдөлгөөнөөр яаран шийд гаргаж болохгүй. Сэтгэлийн хөдөлгөөнөөр гаргасан шийд бүхэн алдаа болдог. Гол нь бусдын саналыг сонсох хэрэгтэй. Надтай нэг баг болж ажиллах хүмүүс маань ч тодорхой байх ёстой.

Хамгийн гол нь найдвартай, шударга, аль нэг тал руу туйлширдаггүй хүмүүс л энэ үед

манай улсад хэрэгтэй байна. Санаанд даанч тийм хүмүүс тэр болгон орж ирэхгүй юм даа гэж бодсон. Тэгээд бодоод байхад нь “Өө, яахав. Болно биз. Би Ерөнхий сайд болчихвол бүх юмыг сайхан болгочихно” гээд юун түүрүүн өндөр албан тушаалын суудал нүдэндээ хараад учир тоймгүй дайраад байх нь зохимжгүй санагдсан. Ер нь ч Монгол Улсын Засгийн газар үнэн хэрэг дээрээ маш хүнд байдалтай байгаа өнөө үед Ерөнхий сайд болно гэдэг дүрэлзэн асч буй гал руу үстэй толгойгоо хийх шиг л хэрэг юм. Ардчилсан хүчний засгийн эрх аваад даруй хоёр жил болоод байгаа энэ үед Монгол Улсын эдийн засгийн өсөлт П.Жасрайн Засгийн газрын үеийнхээс үндсэндээ өсөөгүй. Ялангуяа 1998 он гарснаас хойш үнэндээ уналттай байна. Үүнийг М.Энхсайханы Засгийн газар солигдсонтой зарим нь холбож үздэг, зарим нь болохоор зэсийн үнэ унасантай холбогдуулан Эрдэнэт үйлдвэрийн ашигтай уялдуулах гэж оролддог. Аль нь ч энэ асуудлуудтай нэг их холбогдоогүй. Гол нь Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагаанд гадны үл үзэгдэх гар оролцож байгаатай холбоотой. Ийм болохоор тэрхүү үл үзэгдэх гарын эзнийг олж, эрх мэдлийг нь таслан зогсоох нь нэн тэргүүнд анхаарах асуудал. Зориг энэ тухай хэд хэдэн нөхөдтэйгээ санал солилцсон. Даанч ойлгож байгаа хүн, ойлгохыг хүсч байгаа хүн нэг ч байгаагүй. Бүгд л зөвхөн нүдэндээ албан тушаалтны зөөлөн буйдан, өтгөн кофе харчихаад л “Одоо тэгвэл түүнийг чинь өөрчилье. Тэр нөхөр л бидний замд саад болоод байна. Оронд нь түүнийг тавьчихвал зүгээр байна” гэгцгээж, мөнөөх хувийн арчаагүй ашиг сонирхлыг лоббигоо хийх гэгцгээдэг. МҮАН-ын нөлөө бүхий нөхөд ч, соц-декүүд ч үндсэндээ 1996 оноос хойш иймэрхүү л байр суурьтай байцгаасан. Улс, орон эрх ашигтай холбоотой асуудлууд дээр эрх баригчид сөрөг хүчин ч үнэн чанартаа ийм л байдлаар хандсан. Тийм болохоор С.Зориг М.Энхсайханы Засгийн газрыг огцруулах тухай яригдаж байхад энэ талаар байр сууриа илэрхийлсэн. “Та нар тулга тойрсон юм л яриад байна.

Уг нь өнгөрсөн хоёр жилд юу хийснээ дүгнээд, юу хийх ёстой вэ гэдэг асуудлыг хэлэлцээд шийдвэрээ гаргах ёстой юм биш үү? Би М.Энхсайханыг гайхаж байна. Тэр “хувийн эрх” ашиг хөөцөлдсөн УИХ-ын нөхдүүд, ерөнхий зөвлөлийн нөхдүүд намайг түлхэн унагаах гэж байна” гэх маягийн ойлголтыг бусдадаа өгөх гээд байх юм. Уг нь бол улс төрийн асуудал ярих хэрэгтэй. Юу гэвэл бид нар улс төрийн бөгөөд эдийн засгийн шинэчлэлтийг хийх зорилгыг тавьж 1996 онд гарч ирсэн. Түүнийг хийж чадсан уу, үгүй юу гэдгээ л ярих ёстой. Гэтэл бид түүнийгээ хийж чадсан уу? Чадаагүй. Өнгөрсөн хугацаанд манай улсын эдийн засаг өсөөгүй, манай экспорт, импортын харьцаа муудаад хасах 18 сая ам.доллар гарсан. Түүнийг хэн харж байна. Хэн түүнд эмзэглэж байна. Хэн ч алга. Ерөөсөө манай нийгэм шударга бус тогтолцоотой байна. Та нар Засгийн газрын мэдээ сонинг хар. Төрийн эрх мэдэлд байгаа хэвлэл мэдээллийг хараад би ичиж байна. Хуулийн байгууллагын хүрээнд ч завхрал их байна. Шоронд хүн үхэж байна. Ард түмний эрх ашиг хаа сайгүй хохирч байна. Ер нь цагдаагийн дэглэмтэй гэхэд хилсдэхгүй нийгэм болчихоод байна. Яагаад бид нар энэ тухай ярихгүй байгаа юм. Хүнд сурталтай тэмцэнэ гэж бид гарч ирсэн. Гэтэл хэрэг дээрээ хүнд суртал асар их болчихоод байна. Яагаад юм?

Миний ойлгосноор зарим хүмүүс УИХ-ын гишүүн Засгийн газраа дэмжихгүй байна гэж гайхацгааж байх шиг байна. Бид дэмжсэн. МҮАН-ын олонхи байнга дэмжсэн, үхтэл дэмжсэн. Элбэгдорж, Бат-Үүл нар сайн дэмжсэн. Би бол харин заримдаа эсэргүүцдэг байсан. Угаасаа тийм эсэргүүцэх өвчтэй болоод ч тэр үү, муу гишүүн болоод ч тэр үү эсэргүүцдэг байсан. Бид Засгийн газраа шүүмжлэхээс үргэлж хамгаалж байсан. Одоо больё. Энэ сайн хүн, энэ гол хүн гээд эх орноо боддоггүй, ард олныхоо эрх ашгийг боддоггүй хэн нэгнийг өөгшүүлээд байвал намыг ч, улсыг ч хөгжүүлэх биш саад болох зүйл. Тийм болохоор би та бүхнээс шударга байгаач ээ гэж хүсмээр байна.

Энд бас нэг зүйлийг онцолж хэлэхэд М.Энхсайханы үгэнд “Аэробус болон Эгийн голын усан цахилгаан станцын асуудлыг хувийн сонирхлоор шийдэх гэж байна” гэх маягийн үг цухалзаад байна. Ингэж болохгүй. Өөрсдөө хөлжиж, баяжих гэсэн хүмүүс Засгийн газраа өөрчлөх гэж байгаа бол ёстой болохгүй. Үнэн бол энэ үнэхээр сонин зүйл. Тэгж болохгүй. Тийм асуудал ерөөсөө байж болохгүй. Аэробус болон Эгийн голын асуудлыг УИХ-аар нээлттэй авч хэлэлцэх ёстой. “Боинг”-ийг худалдаж авах нь 30 тэрбум төгрөгийн асуудал. Энэ нь манай одоогийн төсвийн орлогын бараг 20 хувьтай тэнцэж байна. Эгийн голын асуудал бол бүр 300 тэрбум төгрөгний асуудал. Энэ мөнгө бол манай улсын нэг жилийн төсвийн зарлагаас давсан мөнгө. Тэгэхээр ийм асуудлуудыг УИХ-аар олон нийтийн өмнө нээлттэй ярих нь шударга ёсонд нийцнэ”. Зориг яг ингэж л хэлсэн. Түүнээс хойш бас ч үгүй хангалттай хугацаа өнгөрчээ. Түүний үгийг энэ хугацаанд үг гэж үзэн анхаарч үзсэн хүн нэг ч байгаагүй гэхэд хилсдэхгүй. Аанай л нөгөө янзаараа бүх асуудалд зоосны нүхээр, хувийн эрх ашгийн төлөө л бүгд ажиллаж байсан. “Голомт банк”-ны гэдэг Ц.Элбэгдоржийн Засгийн газрыг унагасан маргаантай асуудал дээр хүртэл улс төрчид, улс төрийн хүчнүүд эрх ашгийнхаа төлөө үхэн хатан тэмцэлдэж байснаас улс, орноо бодож хандаагүй. Энэ бүхнийг бодохоор Зоригийн хувьд Монгол Улсын Ерөнхий сайд болно гэдэг байж болшгүй зүйл санагдаж байлаа. Яагаад гэвэл тэр өмнөх Ерөнхий сайдууд шигээ байхыг огт хүсэхгүй. Нөгөө талаас улс төрчдийн үзэл бодол ийм үхээнц дорой, өрөвдмөөр байгаа үед Ерөнхий сайд болно гэдэг бэртэгчингүүдийн тоглоом, цаасан титэмт хүүхэлдэй болчих юм шигээр л санагдаж байлаа. Гэвч сэтгэл зүрхэнд нь хэн нэгэн үл үзэгдэгч хорон санаатны атганд орчих шахаж буй өрөвдмөөр, буурайхан Монгол орноо зоргоор нь хаячихвал дэндүү шударга бус зүйл хийчих гээд байгаа юм шиг гэмшил байнга төрж байв.

Долоо. Далд санаа

“Цагаан харх”-ын үл үзэгдэгч эзэн буурал толгойт эр, “ордны тул” хоёр есөн сарын 31-ний налгар өдөр ихэд нууцлагаар саарал өнгийн бенз хөлөглөн Их тэнгэрийн амаар уруудан Туул голын хөвөөнд очиж шар айраг задлан тухалцгаав. Буурал толгойтын жолооч бадриун бор залуу тэр хоёроос зайдуухан тэрэг рүүгээ ус цацан угааж зогсоно. Буурал толгойт “Чиний гарын хүн гээд байгаа цаад хүн чинь баараггүй хүн олоо биз дээ? Тэр хүн

ч тэгээд хир найдвартай юм бол? Энэ талаар эзэн их санаа зовж байна. Дутуу, гуцуу юм хийж хөөдөх вий дээ. Тэгвэл ч дээр, доргүй бүгд ч баларна шүү дээ. Цаад хүн чинь мөнгөний сонирхол ихтэй хүн болохоор гардагчиддаа гар татаад сүйдэж мэдэх юм шүү?” хэмээн ордны эрээс асуухад нөгөөх нь “Энэ талаар санаа зоволтгүй. Би тэр хүнтэй ний нуугүй ярилцсан. Ер нь ч түүнийг сайн мэднэ. Надтай олон юман дээр гар нийлж ажилласан. Тэр нөхөр надаас урваад ямар ч ашиг олохгүй. Өөрийнхөө толгойг л цусдана гэсэн үг. Үүнийгээ ч сайн мэдэж байгаа. Би урьдчилгаа гээд хэдэн төгрөг өгсөн. Тэрэндээ овоо сэтгэл дүүрэн байх шиг байна лээ. Их л хатуу сэтгэлтэй, чанга гартай хүн. Одоо биднээс өөр түшиж тулж, итгэж найдах хүн түүнд байхгүй. Хоолой дээр нь хутганы ир ирчихээд байхад мань хүн хаашаа ч ухрахгүй л дээ. Харин эзэн та нар мань эрийг тендерт ороход нь ёстой ухрах газаргүй болтол нь мадалж орхисон байна лээ. Мань эр тэр тухай ямар ч сэжиг аваагүй. Бүх бурууг өөртөө л өгөөд явж байгаа. Түүнд одоо өөрийгөө авч гарахад нь бидний захиалга тус болно. Өөр ямар ч яриа байхгүй” гэж учирлав.



Буурал толгойг “Чи цаадахынхаа гардаж хийх хүмүүсийг судалсан биз дээ? Ямархуу хүмүүс байна?” гэж шантаажлан асуухад саарал ордны эр “Гардаж зохион байгуулж байгаа хүн нь Ху овогт гэдэг КГБ төгссөн 40 эргэм насны туранхай эр байх шиг байна лээ. Яг үнэндээ гардах хүмүүсийг л сайн мэдэхгүй байна” хэмээн хэлэхэд буурал толгойг хэсэг зуур чимээгүй байснаа “Муу л байна даа. Асуудал яаж ч эргэж мэдэх юм. Гардагчууд илэрч баригдсан тохиолдолд гардан зохион байгуулагчийг дор нь устгахгүй бол бид өөрсдөө илэрч мэднэ. Болж л өгвөл чи өөрийнхөө хяналтад бүгдийг л оруулах ёстой шүү

дээ. Тэгээд ч ер нь юун түрүүн гардагчдыгаа үгүй хийх төлөвлөгөөг одоо боловсруулчихсан байх хэрэгтэй шүү дээ. Ямар ч үед түүн шиг зөв юм байхгүй л байх. Эзэн чамайг иймэрхүү янзтай байгааг мэдвэл их л уурлах байх. Би ямар эзнээс энэ бүхнийг нуугаад байлтай биш. Эзэн чамд итгэдэг л дээ. Гэхдээ итгэл гэдэг чинь хэзээ ч эвдэрч болох зүйл биз дээ?” гэж үгээ зөөн зуунгидуухан өчив. Саарал ордны эр “Та эзэнд аль болох эерэг талаас нь яриарай. Би маргааш бүх зүйлийг тодорхой болгочихсон байна. Тэгээд бас та нараас гуйх нэг юм бол ерөнхий зохион байгуулагчийг одооноос анхааралдаа аван, болж өгвөл бүх зүйл дууссаны дараа зохицуулчихвал яасан юм бэ?” гэв. Буурал толгойт “Чи мэдэж байгаа. Эзэн Зоригийг дээш нь гаргах тухай яриа болсноос хойш энэ талаар санаа зовж эхэлснийг сайн мэдэж байсан. Зориг бол бидэнд маш аюултай хүн. Тэр Ерөнхий сайдаар гарч ирвэл бидний эсрэг хүчтэй үйл ажиллагаа явуулж эхлэх нь тодорхой. Шударга хүн гэдэг дүрдээ итгэчихээд юу ч хийхээс сийхгүй. Бид Зоригтой зарим зүйл дээр тохиролцох гэж үзсэн. Ёстой ойлгомжгүй хүн. Шударга ёс гэдэг хоосон мөрөөдлөө өмнөө барьсан, тэр мөрөөдлөө байдаг гээд итгэчихсэн хүн. МҮАН-ынхан С.Зоригийг Ерөнхий сайд болох тал дээр санал нэгдчихээд байгаа юм шиг байна.

С.Зориг Ерөнхий сайдад ногоон гэрлээр гарч магадгүй хүн. М.Зэнээ, О.Дашбалбар нарын ардын хүүхдүүд гэж өөрсдийгөө үздэг хүмүүс түүнийг дэмжих нь тодорхой. Ер нь ч “Ху” намын нэг бус хүн түүнд талтай. Дээр нь Ерөнхийлөгч Н.Багабанди С.Зоригийг хэл аманд өртдөггүй болохоор нь ямар нэгэн асуудалгүйгээр дэмжих нь зайлшгүй нөхцөл байдалтай байхад Зориг Ерөнхий сайд болох магадлал ихтэй байна. Тэгээд ч ер нь С.Зоригийг Ерөнхий сайд болсон ч бай, болоогүй ч бай аль ч тохиолдолд үгүй хийх нь “Цагаан харх”-ын ирээдүйд чухал ач холбогдолтой. Юун түрүүнд олон улсад болон дотооддоо нэр хүндтэй түүнийг гүйцэтгэх засаглалд гарч, бидний эсрэг үйл ажиллагаа явуулж амжаагүй байхад нь устгах хэрэгтэй. Манай саарал ордны нөхөд ч энэ тал дээр санал нэгтэй байх шиг байна лээ. Хоёрдугаарт, шударга ёс, улс орны эрх ашиг гэж өвчигнөдөг зарим улс төрчдөд түүний үхэл сургамж болж, тэд ам хамраа үдэж аваг. Гуравт, Зориг алагдвал улс төрийн тогтворгүй байдал үүсэх магадлалтай. Аль болох Монголын улс төр тогтворгүй байвал “Цагаан харх” төдийчинээ хурдан байр сууриа бэхжүүлнэ. Тийм болохоор эзэн улс төрчдийн дунд булууны яс болгож хаяхаар гардагчдаар нь “дараагийнх нь Бат-Үүл гэж хэлүүл” гэж шаардаж байгаа юм. Тэр тохиолдолд цаад цагдаагийнхан чинь “Энэ Бат-Үүл гэдэг нөхөр өөрийгөө сүрхий чухал хүн болгож рекламдах гээд С.Зоригийг алуулчихаж” гэлцээд чулуу хөөж, бидэнд өөрийгөө хангалттай далдлах боломж олгоно. Ийм болохоор энэ ажилд ямар ч хариуцлага алдаж болохгүй” хэмээн өгүүлснээ дууныхаа өнгийг өөрчлөн “Одоо ингээд буцах уу даа” гээд үгээ дуусгав.

Саарал ордны эр буурал толгойт руу нэг сүрхий харсанаа “Маргааш би тань руу утасдъя даа” хэмээв. Буурал толгойт цагаан ордны эрийн үгэнд ямар ч хариу өгөлгүй шилтэй шар айргийг амаар нь гүд гүдхийгэл нь залгиллаа. Буурал толгойт эр тийнхүү залгилж байхдаа дотор хүнтэйгээ “Хэрвээ гардагчид баригдаад байдал эргэвэл яалт ч үгүй саарал ордны энэ чухал хүнээ хөнөөж л таарах байх даа. Харамсалтай л юм. Гээд одоо яахав дээ” гэж шивнэлдэж байсныг дэргэд нь суугаа мөнөөх хүн нь яахин тааварлах билээ. Буурал толгойт нэгэн амиар шахуу шилтэй пивоо хоослоод нэгэнтээ сүрхий хэхэрсэнээ “Тэгье дээ. Маргааш уулзъя” гээд суудлаасаа өндийлөө. Төд удалгүй тэд жолоочоо дуудан их хотын зүг нэг л их яарсан маягтайгаар хурдлан алга болов. Хатан Туул гол зууныг донсолгосон, монголчуудын зүрхэнд шар ус хуруулсан аймшигт алуурчид хөвөөнд нь

сууж үл үзэгдэгч ирт мээсээ хурцалж байгаад явсаныг анзаарсан мэтээр айсан ботгоны нүд шиг мэлэрсэн хар долгиогоо мяралзуулан үлдлээ.

Найм. Тоглоом

Цацрал ажил дээрээ байж байгаад заналхийлэлд өртсөнөөсөө хойш хэн гээч амьтан түүн рүү ярьсан байж болохыг олж тогтоох гээд хоёр хоног тамаа цайв. Тэрбээр энэ талаар хэлтсийнхээ зарим офицеруудтай санал бодлоо солилцоход “За даа. Шал дэмий л юм байна даа. Манайд улс төрийн захиалгат аллага гарна гэж юу байдаг юм. Солиотой, шизотой нэг нөхөр дэмий юм ярьчихаад л түүнийгээ чамд итгүүлэх гэж арга саам зохиож л байхгүй юу. Чи өөрөө ч мэдэж байгаа шүү дээ. Хавар, намар хоёрт л манай гудамжны улс төрийн зүтгэлтнүүдийн өвчин хөдөлдөг гэдгийг. Тэдний улирлын шинтэй өвчин нь хөдөлчихөөд балайрч байхгүй юу. Арай чи дарга нарт энэ тухай мэдээлж нэр хөөдөөгүй биз дээ? Саарал ордныхон бие биенээ захиалж алуулна гэж одоохондоо байхгүй. Тэд нар чинь өнгөн дээрээ бие биенээ нэг л их ална, шулна гэж сагсуурцгаадаг хэрнээ цагаа болохоор юу ч хийж чадахгүй цагаан гартай улс. Бодоод үз л дээ. Хэн нь хэнийгээ алж, хөнөөх гээд байгаа юм. 90-ээд оноос хойш л тэд нэг сүрхий улс намайг алах гэлээ, тагнах гэлээ, сүйд хийх гэлээ гээд л бөөн өргөдөл чирэгдэл болон сүр үзүүлж байсан. Одоо тэгээд тэр олон тохиолдлуудын аль нь ч үнэн байгаагүй шүү дээ. Шал утгагүй юм. Наадахыгаа орхи” гэгцээсэн юм. Цацрал хэлтсийнхээ нөхдүүдийн үгийг дагаж, уг болсон явдлын талаар дээш, доош нь ямар ч мэдэгдэл явуулсангүй. Түүн рүү заналхийлж утасдсан эрийг таксофоноос ярьсан гэж холбогдох албаныхан мэдэгдсэн. Тэгж бодохоор зохион байгуулалттай зүйл шиг байгаа юм. Гэлээ гээд аль амьтан таксофоноос ярихыг тэр гэхэв дээ. Гэртээ утасгүй, ажил дээрээ утасгүй нэг эр л хий таксофоноор яриа биз. Тэгээд ч ер нь дээд түвшинд зохион байгуулагдаж байдаг улс төрийн захиалгат аллагыг гудамжны нэг нөхөр яриад явж байна гэдэг байж болшгүй зүйл юм шиг. Цацрал сайн бодоод уг асуудлыг мартаж орхиё гэж үзсэн.

Гэвч сэтгэлийн угт нь ямар нэгэн юм болох гээд ч байгаа юм шиг мэдрэмж төрөөд байхаар нь бөөн эрэл сурал болж байж мэдээлэл өгсөн эрийг олж уулзах гэж хичээсэн. Гэвч тэр олддоогүй юм. Тэгж эрэл сурал болж явахдаа Цацрал гудамжны хөдөлгөөнийхөнтэй уулзаж, тандаж үзсэн юм. Тэгэхэд цаадуул нь ордон тойрч хашгирахаас биш ордонд юу болж байгааг ер мэдэх сэхээгүй амьтад байлаа. Харин ч бүр гудамжны хөдөлгөөн гэгдэж байгаа тэр хэдэн хүмүүс хэний эсрэг, хэний төлөө Ялалтын талбай дээр гэр барьчихаад сууж байгаагаа ч ойлгодоггүй хүмүүс байхыг хараад дургүй нь хүрсэн юм. Бараг л орон гэргүй шахуу тэр хэдэн хүмүүс хотын төвд гэр барьчихаад дотор нь гудас дэвсгэрхэн хаяж, түүн дээрээ унтаж шөнийн бор хоног өнгөрөөдгийг ойлгоод “Хүн гэдэг амьтан ч амьдрахын төлөө янз бүрийн л юм сэдэх юм даа” хэмээн бодсон. Тэр хэдэн хүмүүс улс төрийн захиалгат аллага хийх нь бүү хэл хоногийн хоолоо олж идэж чадахааргүй арчаагүй хүмүүс юм байна гэдгийг анзаарсан. Тэгээд “Ийм хүмүүсийн улс төрийн тэмцэл гэж юу байхав дээ. Арга ядсан л хэрэг юм. Ажил төрөлгүй, мөнгө төгрөггүй болохоороо л бухимдсан сэтгэлээ дарах гэж ингэж цаг хугацааг дэмий өнгөрөөж байна. Ингэж дэмий бүтэхгүй зүйлийн төлөө дүрдээ итгэн амьдралынхаа үнэт цагийг алдаж байхаар өөр өөрсдөдөө тохирсон ямар нэгэн ажил хийвэл өөрсдөд нь хэрэгтэй. Ийм учир утгагүй тэмцэл, шаардлагыг саарал ордон яаж хүлээж авахав дээ” гэж санасан. Тэгэхдээ Цацралын тархи толгойд үүний зэрэгцээ “Үгүй ээ. Харин энэ хүмүүсийг гадны болон дотоодын янз бүрийн бүлэглэлүүд золиос болгон ашиглах гэж болох л юм даа. Америкт хүчээ авсан

Хятадын гудамжны нөлөө бүхий бүлэглэлийн нэг болох Тонгийнхон Америкт аллага, дээрэм хийхдээ мөрөө баллах зорилгоор Нью-Йорк, Вашингтоны зарим нэг шашин болох улс төрийн анархистуудыг үйлдсэн мэтээр цуу дэгдээх, хэргийн газар тэдний эд зүйлсийг нотлох баримт болгох зорилгоор үлдээдэг гээ биз дээ.

Манайд ч гэсэн Тонгтой төстэй гэмт хэргийн нууц бүлэглэл бий болчихоод хууль бус үйл ажиллагаанд л саад болж болох хэн нэгэн улс төрчийг алахынхаа өмнө зориудаар шуугиан дэгдээж, хууль хяналтынхны бүх анхаарлыг гудамжны хөдөлгөөнийхөн рүү чиглүүлэх гэж заль зохиож, эд нарыг ингэж өөгшүүлж байгаа юм биш биз дээ. Мэдээж, тэр тохиолдолд манайхан болон цагдаагийнхан хэрэгтэн этгээдийг гудамжны хөдөлгөөний хэдэн үл бүтэх нөхдийн дундаас олох гэж багагүй цагаа алдана. Яах ч учраа олохгүй байгаа энэ хэдэн хүмүүс худал, үнэн юм ярьж хуулийг ч, өөрсдийгөө ч хүндрүүлнэ. Ийм нэг үйл ажиллагаа зохиогдож байж болох талтай. Хэрвээ энэ үнэн бол саарал ордонд байдаг туслахын маань хэлсэн “Торгоны зам”-ын нууц эзэд Монголд байна гэсэн үг болно. Тэгэхлээр манайхан мэргэжлийн хүмүүс ч төдийлөн мэдээд байдаггүй мафизмын далд аллагыг монголчууд хийж байдаг нь зайлшгүй болно. Бид л өөрсдийгөө “Монголчууд цагаан цайлган зантай. Хүнд тусархуу, зөөлөн сэтгэлтэй, монгол хүмүүст улс төрийн зохион байгуулалттай аллага хийх сэтгэлзүй байхгүй” хэмээн хөөрөгддөг болохоос биш манай Монгол Улс бол яг үнэндээ аймшигтай гэмт хэргийн үүр болсон орон шүү дээ. Өнөөдөр Монголд аллага болдоггүй өдөр гэж бараг л байдаггүй гэхэд хилсдэхгүй. Дээр нь үнэндээ монголчууд энэ ХХ зуунд дэндүү аймшигтай захиалгат аллага, үй олноор нь хоморголон устгах аллагыг зохион байгуулсан улс. Энэ зууны эхэн үед захиалгат аллагаар Да лам Цэрэнчимэд, Дайчин ван Ханддорж, Сайн ноён хан Намнансүрэн нарын зэрэг цөөнгүй эх орончид хөнөөгдсөн. Дараа нь ардын хувьсгалын эхний жилүүдэд Ерөнхий сайд Бодоо, баруунтан гэгддэг Данзан, Баваасан, жанжин Сүхбаатар нарын олон эрс бас л хэн нэгний захиалгаар алуулсан.

30, 40-өөд оны үед бол нийтдээ 36 мянга гаруй сэхээтэн, язгууртан, лам, хар гээд нийгмийн бүх л давхарт идэвхтэй эрс зохион байгуулалттай аллагын бай болсон. Түүний дараа 50, 60-аад онд олон арван тэргүүний сэхээтэн хэн нэгний захиалгаар ажил, амьдралгүй болон үндэс угсаагаараа хохирч байсан. 70, 80-аад онд ч Д.Төмөр-Очир гэх зэрэг нэр хүнд, өндөр албан тушаал бүхий хүмүүс захиалгат аллагын золиосонд хөнөөгдсөн. 90-ээд он гарснаас хойш ч зарим нэр бүхий хүмүүс, урлагийнхан захиалгат аллагад өртсөн нь ч нууц биш. Зохиолч Ж.Бямба, сэтгүүлч Сэсмээ, орчуулагч Алтанхуяг, дуучин Баяраа, Төмөр нарын үхэл захиалгат аллагын бай гэж хэлж болохоор л байсан. Бодит байдал бол үнэндээ ийм л байдаг. Тэгэхлээр өнөөдөр ч гэсэн хэн нэгэн бусдыг захиалан алуулах гэж цус үнэртүүлсэн мөнгөө алуурчны хормой руу сэмхэн шургуулж байгааг үгүйсгэх аргагүй юм”. Цацрал ингэж бодоод мэдээлэгч эрийн үг үнэн биш байгаа даа хэмээн дотроо эргэлзсэн. Аллага болдог юм бол мэдээлэгч эрийн хэлснээр гудамжны хөдөлгөөний хэдэн үл бүтэх хүмүүс биш өөр хүмүүс өөр замаар уг аллагыг хийх нь тодорхой. Харин тэр хэн байх нь л Цацралд сонин байсан. Тэгээд тэр хүмүүс Цацралыг чулуу хөөлгөх тоглоомынхоо гол тоглогч болгох гээд байгаа нь нэг л учир битүүлэг санагдсан. Цацрал дотоод сэтгэлдээ буй энэхүү эрс тэрс хоёр хүчин зүйлийнхээ алийг ч сонгож чадахгүй учрыг ойлгох гэж тамаа цайсан. Эцсийн эцэст тэгээд юу ч болж байсан бүхнийг чив чимээгүй харж байх нь хамгийн зөв шийдвэр юм байна л гэж бодсон.

Ес. Айдас

Ордны тул хэмээгдэгч албан тушаалтан эр Туулын хөвөөнд “Цагаан харх”-ын эзний төлөөний итгэлт хүн гэх буурал толгойттой уулзсан тэр оройдоо амьдралдаа сандарч байгаагүйгээр сандарч, барьц алдаж байгаагүйгээрээ барьц алдав. Монгол Улсын нэг сая 500 км.кв газар нутаг дээр хэзээ ч өвдөг нахийж явахгүй гэж дотроо ихэд бардам бодож явдаг түүнд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, тагнуул, цагдаагийн дарга нар зүгээр л нэг юмны учир ойлгодоггүй хүүхэд шиг санагддаг. Тэдний хэнээс ч тэр эмээж яваагүй. Дэндүү бага байхдаа, арван жилийн бага ангийн сурагч байхдаа л тэрбээр бусдаас айж байсан байх. Үе тэнгийн зарим банди нар ном дэвтрийг нь булааж шоглох, гуанзных нь мөнгийг дээрэмдэх явдал нэг бус удаа гаргаж байсан. Тэгэхэд тэр дотроо хий л өширхөхөөс өөр яаж ч чаддаггүй байсан. Харин том ангид ороод тэр амьдралын ухаанд суралцаж, бусдын арга эвийг амархаан олчихдог болсон. Бусдаасаа арай л нэг чадалтай, хүчтэй банди нарт тэрбээр тал засан карман дахь мөнгөө нэхээгүй байхад нь л тамхины мөнгө гээд өгчихдөг болсон. Заримдаа эцэг, эхээсээ тав арван цаас гуйж аваад тэднийг цай, хоолонд урьж орхидог байсан. Түүнээс хойш хэн ч түүнд гар хүрээгүй. Бүгд л эр хүн шиг зантай, дажгүй банди гээд л мань эрийг дархалж орхисон. Амьдралаас түүний олж авсан хамгийн урт бөгөөд өгөөжтэй зан нь энэ л байсан. Аравдугаар ангиа төгсөөд оюутан болж, дараа нь ажил дээр гараад тэр энэ арга, энэ зангаа орхиогүй. Өөртөө хэрэгтэй гэсэн бүхэндээ эвийг нь тааруулж, тал засч явах нь нэг ёсондоо түүний ажил бөгөөд хамгийн шилдэг мэргэжил нь болсон. Улс төрд ч гэсэн тэр энэ замаар маш хурдан гарч ирсэн. Яваандаа тэр хүний итгэлт, найдвартай найзын дүрд тоглож байгаад түүнийгээ өдөр тутмын хэвшил болгоод тэр дүрээрээ хаа, хаагүй л тоглож явдаг болсон билээ.

Тийм болохоор Монголын улс төрийн томоохон өндөрлөгт буй ихэнх хүмүүс л түүний найз нөхөд болон хор найруулгынх нь гар, хөл болцгоосон. Түүний оролцоогүйгээр дээш мацаж гарсан хүн даанч цөөхөн. Энэ бүхэндээ ордны тул гэж “Цагаан харх”-ынханд нэрлэгддэг болсон. Тэрбээр барагтайхан аавын хүүг хурууныхаа ганц дохилтоор л хувь заяаг нь шийдчихдэг нэгэн болсон. Түүнд бусдаас айх, түгших зүйл даанч байхгүй болсон. Харин түүний бүхий л хувь заяаг нь өөрчилж өгсөн “Цагаан харх”-ынхан мань эрд аймаар, сүрдмээр санагддаг. Санаанд таарахгүй нэгнийг нүд ирмэхийн төдийд л ам арчсан цаас мэт базаж орхидог “Цагаан харх”-ын нууц эзнээс тэр айж, болгоомжилж явдаг билээ. Учир нь, “Цагаан харх”-ынхан түүнийг дээш нь яаж гаргаж ирсэн шигээ хүссэн өдрөө л доош хийчих нь тодорхой тул айхаас ч аргагүй байдаг юм. “Цагаан харх”-ын үл үзэгдэгч эзний ганц найдвартай түнш гэлцдэг буурал толгойт эр Туулын хөвөөнд урьж аваачихаад нэг л далд утгатай, заналхийлсэн янзтай байхаар нь тэр ухаан жолоогүй айсан. Тэгээд тэр даруй Туулын хөвөөнөөс ирэнгүүтээ өөрийнхөө гар, хөл болсон бизнесмэн эрийг дуудаж уулзсан юм. Бизнесмэн эр түүнд “Та битгий санаа зов. Манай хүмүүс чинь мэргэжлийн, мэргэжилдээ гаршсан хүмүүс шүү дээ. Алдаа мадаг гаргахгүй байх гэж би найдаж байна. Өмнө нь ч би тэр хүмүүстэй хамтран ажиллаж байсан. Бүх юмыг л яв цав гүйцэтгэдэг улс. Тийм хүмүүс худлаа ярина гэж байдаггүй юм. Тав арван цаасан дээр нь л гар татахгүй байхад бүх зүйл жин тан гэсэн үг. Та санаж байгаа байх. Хэдэн жилийн өмнө Америкийн нэг хөрөнгө оруулагч эр манайд цохондоо буудуулж алагдсаныг. Тэр аллагыг чинь манай энэ ерөнхий зохион байгуулж байгаа эр гардаж хийсэн юм шиг байна лээ. Зоригийг бодвол харьцангуй хар ихтэй, буруу зөв юманд хутгалдаж байсан тэр эр ёстой “га” ч гэж дуугарахгүй өнгөрсөн шүү дээ.

Араас нь Интерполынхон, тагнуулынхан, мөрдөнгийнхөн ажиллаад ямар ч үр дүнд хүрээгүй. Дэндүү цэвэрхэн хийсэн байсан. Дээр нь тэгээд ч цагдаа, тагнуулын албанд танайхны хүмүүс зөндөө л байгаа биз дээ? Тэр хүмүүс чинь ч гэмт хэргийн мөр баллуурдахад оролцох юм байгаа биз дээ. Санаа зовох хэрэггүй дээ. Би энэ ажилд бүх анхаарлаа төвлөрүүлж ажиллаж байгаа. Манай хүмүүсийн яриагаар аллага гардан үйлдэгчид бол урьд өмнө нь нэг их цагдаа, хорихынхны анхааралд өртөж байгаагүй хэрнээ тэр ажилдаа гаршсан хүмүүс гэсэн. Бид ярьж байгаад аллагыг хоёр хүнээр гардуулах болсон. Бие биенээ сайн таньж мэдэхгүй хүмүүс байгаа. Нэгийг нь бид бүр эмэгтэй хүн байхаар төлөвлөсөн. Тэр эмэгтэй бол бидний найдвартай хүн. Хоёр, гурван удаа зохион байгуулсан операцид сайн ажилласан. Үнэндээ хүмүүсийн хэлдгээр шулам шиг л хүүхэн дээ. Тэгэхдээ бүр хүний цус уудаг гаж донтой яахаас ч буцахгүй шулам шиг л хүүхэн байгаа. Бид тэр хүүхэнд давхар даалгавар өгсөн. Хамтран гардагч нь аллага дутуу орхивол заавал гүйцээх. Операцийн ажиллагаа бүтэлгүйтэж илрэхээр болвол хамтрагчийгаа хөнөөх даалгавар өгсөн. Аллагыг гардагчид маань яг баригдаад явчихвал эрэгтэй нь амьд үлдвэл осолтой. Өмнө нь орон шоронд орж яваагүй хүн болохоор гэнэ алдаад зохион байгуулагчдыгаа илрүүлчихэж магадгүй. Харин тэр хүүхэн бол шал өөр. Манай хүмүүс тэр хүүхнийг гурван сарын өмнө турших зорилгоор багагүй эрүүдэж үзсэн байсан.

Улаан нялга болтол нь нүдээд ч хашрахгүй хүүхэн байна гэж байсан. Яс юман дээр хүүхнүүд чинь эрчүүдээс хамаагүй тэвчээртэй улс юм шиг байна аа даа. Хүүхэд, шуухад төрүүлэхээс эхлээд амьдралын янз бүрийн зовлон хангалттай амссан байдаг болохоор ямар ч өвдөлтийг тэсвэрлэх чадвартай байдаг шиг байна. Дээр нь бас хүүхнүүд чинь эрчүүдийн дарамтад хамаг цагаа өнгөрөөдөг болохоор хэрэг дээрээ ам чангатай улс байдаг бололтой юм. Тэр хүүхэн гардагчийгаа хөнөөчихсөн тохиолдолд бидэнд айх зүйл хамаагүй бага байна. Шоронд тэр хүүхнийг дарамтлаад байх хүүхэн нэг ч байхгүй. Тийм болохоор шоронгийн гүйцэтгэх ажлаар түүнээс ам алдуулна гэж байхгүй. Мөрдөн байцаагчид ч гэсэн эмэгтэй хүн болохоор нь харьцангуй эрүүдэн тамлахгүй энэ бүх үндэслэлээр тэр хүүхэн бидэнд хангалттай цаг өгөх болно. Түүний дараа бид хүүхнийг янзалчихаж хангалттай чадна шүү. За, одоо ингээд яриад байвал нарийн ширийн зүйл хангалттай их байгаа. Энэ бол бидний А төлөвлөгөөний ерөнхий зүйл. Нарийвчилсан зүйлүүдийг нь зохион байгуулж байгаа хүмүүс нь мэдэж байгаа. Та бид тэр хүмүүсийг авчраад яах гэж байна, одоо юу хийх гэж байна гэлцэж, хуарангийн социализмын нэгдлийн дарга шиг гэнэн ажил хийгээд хэрэггүй биз дээ. Ухрах, буцах газар байхгүй юм чинь. Юу болохыг тэвчээртэйгээр харж л байя” гэж өгүүлсэн юм. Саарал ордны эр бизнесмэн эрийн итгэл төрүүлсэн ярианд жаахан ч атугай тайвширсан хэдий ч “Цагаан харх”-ын эзний итгэлт хүн болох буурал толгойтын хэлсэн үгийг санахаараа л өөрийн эрхгүй түгшиж байлаа.

Арав. Золбин

Хүүд аав ч, ээж ч, ах, эгч, дүү ч байгаагүй аж. Хэн ч түүнийг “Миний хүү” хэмээн дуудаж байсангүй. Бүгд л “Золбин, хөөе золбин” гэж дуудна. Тийм болохоор хүү өөрийгөө золбин гэдэг юм байна гээд ойлгочихсон хэрэг. Харин хүүд нэг өвөө байсан. Өвөө нь гэнэт л нэг өдөр хаашаа ч юм яваад алга болчихсон. Хүмүүс өвөөг нь бурхан болсон гэж хэлсэн. Хүү тэгэхлээр нь Гандан орж өвөөгөө баахан хайсан. “Энэ олон бурхны аль нь өвөө маань юм

бол доо? Дотор нь ороод суучихсан юм байх даа” гэж бодоод өвөөгөө эрсэн боловч хөлдүү, хатуу чулуун бурхдын аль нь ч өвөө нь биш байсан. Нэг хэсэгтээ хүү тийнхүү Гандан гарч өвөөгөө хайдаг ажилтай байснаа сүүлдээ яагаад ч юм өвөө нь тэндээс хэзээ ч олохгүй юм шиг санагдаад тэгсгээд л больчихсон. Хүүг хүмүүс өвөөгүй болсноос нь хойш нэг ч удаа хүн гэж үзээгүй. Эхийнхээ толгойг залгисан заяа муутай амьтан гэгцгээдэг байсан. Тэгэхлээр нь хүү өөрийгөө “Би хүн биш байх. Эхийнхээ толгойг залгисан юм чинь хүн байж яасан ч таарахгүй” гэж боддог болсон. Хүмүүст дулаан гэр, орон байр, идэх хоол байдаг бол хүүд аль нь ч байгаагүй. Хүү яг л нохой шиг гадуур тэнэж, нохой шиг хаа дуртай газраа унтаад өгдөг байсан. Тийм болохоор хүү өөрийгөө нохой л байх гэж боддог болсон. Тэгээд нэг удаа өвлийн шөнө гудамжинд учиргүй их даарахын эрхэнд нохой шиг хуцаад байвал даарахгүй байж магадгүй гэж санасан. Хүү сар руу харж байгаад яг л нохой шиг дөрвөн хөллөж байгаад нэг л их хуцаж үзсэн. Хүүгийн хуцах дуу нь нохойных шиг биш нэг л турь муутай гонгиносон юм өөрт нь сонсогдсон. Хүү тэгэхлээр нь “Би яг л гөлөг юм байна. Гөлөг л ингэж дуугардаг шүү дээ” гэж санаад өөрийгөө гөлөг юм байна гээд итгэчихсэн. Гөлөгнд ч бас эх байдаг болохоор хүү эхтэй больё гэж бодоод гудамжинд явж буй нэг жингэрийг өдөржин дагасан. Хүний урманд өнөөх жингэр нь түүнийг нэг нүдээрээ тоож хараагүй.

Идэж буй булууны ясыг нь хажуугаас нь мэрэлцдэг юм бил үү гээд дөхтөл өмнөөс нь аймаар том шүдтэй амаа ярзайлган архирсан. Хүү тэр жингэрээс айгаад дахиж нохой руу ойртохоо больсон юм. Дараа нь хүү золбин нохой байснаас айлын тэжээвэр нохой байвал хамаагүй дээр юм байна гэж бодсон. Тийнхүү гунигтайгаар бодоод гудамжинд явж байтал нь жижигхэн цагаан хав хөтөлсөн нэгэн авгай тааралдсан юм. Авгай мөнөөх цагаан хавандаа хүүгийн амьдралдаа идэх нь бүү хэл харж үзээгүй зүсэн зүйлийн хоол өгөхийг хараад ерөөсөө энэ авгайн тэжээвэр нохой больё гэж шийдсэн. Тэгээд эзнийхээ хөлийг долоон эрхлэх цагаан хавыг дууриан өнөөх авгайд сэмхэн мөлхөн дөхөж очоод хөлийг нь илбэтэл “Пөөх, паах, пүү, пай” болоод л нөгөө авгай чинь хүүгийн толгой руу барьж явсан шүхрээрээ хэдэнтээ гөвшиж орхиод л цагаан хаваа тэвэрч аваад хүүгээс зугтах мэт арилж өгсөн. Уул нь хүү баян авгайн тэжээвэр нохой болчихоод л авгайд эрхлэн аз жаргалтайгаар гэдэс цатгалан амьдарч явъя гэж санасан хэрэг л дээ. Авгай хүүгийн тэр санааг даанч ойлгоогүй. Хүү түүнээс хойш “Би ерөөсөө нохойноос дор амьтан юм, нохой л лав биш. Хүн бол бүүр ч биш, хүн гэдэг чинь хачин гоё машин унадаг, сургуульд сурдаг, театрт орж сайхан сайхан юм үздэг, халуун усанд ордог, бүгдээрээ хамтдаа аз жаргалтай амьдардаг гэсэн. Би тэгэхлээр хүн бол биш. Би тэгээд бас нохойноос шал дор амьтан. Нохой бол ерөөсөө өлсөхгүй, хүмүүсийн хаясан яс насыг дор нь л үмхээд идчихнэ.

Нохой бас даарахгүй, гадуураа хачин дулаахан үстэй болохоороо өвөл ч байсан даарахгүй. Хүн, нохой хоёр аль аль нь жаргалтай юм. Харин би бол азгүй амьтан. Зүгээр л нэгэн золбин. Хүн ч биш, нохой ч биш ерөөсөө л золбин. Ядаж хүн биш юм аа гэхэд нохой болчих юмсан. Тэгвэл ингэж өлсөхгүй дээ, ингэж даарахгүй дээ” хэмээн гунигтайгаар

мөрөөддөг болсон. Хүү тэгж даанч олон удаа өлсөх бүртээ, даарах болгондоо мөрөөдсөн. Хүүд өлсдөггүй, даардаггүй өдөр гэж ер байгаагүй. Хүү нэг удаа “Өвөө маань байхад би энэнээс арай л дээр байсан. Өвөө өдөржин хог түүгээд тэр хогноос олсон хоолныхоо шавхруугаар надад хоол хийж өгдөг байсан. Өвөө бас хүйтэн өдөр болохоор гал түлээд намайг дулаацуулдаг байсан. Ерөөсөө өвөөтэйгээ амьдарч байсан “Цагаан даваа”-ны хогон дээр очиж өвөө шигээ амьдаръя. Тэгж байгаад бас бурхан болоод өвөө дээрээ очиж уулзъя” гээд “Цагаан даваа”-ны хогон дээр очтол эрэгтэй, эмэгтэй хоёр амьтан байсан. Нүүр нь пад харласан, үс гээг нь сэгсийж сагсайсан, хөл гар нь сайртсан тэр амьтад хүн бол биш байсан. Тэд хүүг хараад аймаар муухай хашгиран хөөсөн. Эмэгтэй амьтан нь бүр хүүг хөөж барьж аваад нүд рүү нь хог цацаад “Ахиад чамайг энд ирвэл шууд л алаад хаячихна шүү” гэж занасан.

Хүү хог нүдэнд нь орж хорсогохоор байж ядталаа чарлан уйлсан. Хамаг тэнхээ чадлаа бартал тийнхүү чарлан уйлсныхаа эцэст хүү жаахан ч атугай тайвшрах шиг болсон. Хүү тэгж уйлж тайвширсныхаа дараа “Би хүн биш, нохой биш, өвөөгийн оромжинд байгаа тэр муухай хоёр амьтан шиг л юм байна. Өвөө бас амьтан байсан юм байна. Тийм болоод ч өвөө “Энэ дээдсүүд л, саарал ордныхон л өөрсдөө хагартлаа баяжаад биднийг хүний ёсноос гаргаж хүн биш болголоо. Энэ муу хүүгийн эх өвчнөө даасангүй дээ. Хүн шиг амьдралтай, хүн шиг наад захын хөрөнгө, мөнгөтэй байсан бол юу гэж үхэхэв. Залуу зандан болохоороо эдгэрээд босоод ирэх байсан. Надаас хойш энэ хүү нь л их зовно доо. Энэ мууг хүн гэж үзэх амьтан байх биш” гэж нэг танил өвгөндөө ярьж байсан. Тэгэхлээр миний ээж ч бас хүн биш байсан юм байна” хэмээн бодсон юм. Хүү тэгж бодоод “Өвөөгийн оромжинд байсан тэр муухай хоёр амьтан шиг байснаас нохой болсон нь дээр, ерөөсөө нохой л больё” гэж шийдсэн. Хүү тэгэхдээ бас өвөө нь нэг удаа “Энэ саарал ордныхон биднийг анхаарч үздэг бол юу байхав дээ. Дорхноо л бид чинь өөр болоод хүн шиг амьдралтай болчихно. Би насаараа энэ Монгол улсын хилийг хамгаалж, халуунд нь халж, хүйтэнд нь хөрч ихийг үзсэн. Эцэст нь ийм л амь амьдралтай болдог юм байна даа. Тэр Зориг гэдэг хүү уул нь ард түмнийхээ төлөө гэсэн сэтгэлтэй хүн шиг байгаа юм. Даанч цаадуул нь түүнийг дээшээ гаргахгүй болохоор яаж ч чаддаггүй юм шиг байна лээ, зайлуул” хэмээн ярьсныг санасан юм. Тэгээд хүү “Тэр Зориг гэдэг хүн нь дээш гарчихаасай даа” гэж сэтгэлдээ залбирч явдаг болсон билээ.

АРВАННЭГ. ТӨӨРӨГ

Хүү нохой болох гэж маш их зовсон. Эхлээд түүний бүх бие дагжтал чичрэн, хамаг эрхтэн нь салчих шахам өвдөөд байхаар шуудхан л нохой болчихвол өвдөх ч үгүй, даарах ч үгүй амар болчих байхдаа гэж мөрөөдсөн. Гэвч хүслээр нь болоогүй. Хүү бүр гурав, дөрвөн өдөр тийнхүү өвдөж, чичирч үйл тамаа эдэлсэн. Тэгж байгаад нэгэн сартай шөнө ингэж зовж байхаар юу ч сонсдоггүй, юу ч мэдэрдэггүй мод, чулуу болчих юмсан гэж хүссэн. Хүү тэгэхдээ “Шороо болвол бас л зовох байх даа? Хүн болгон миний дээр гишгэнэ, бас энэ олон машин, тэрэгнүүд үргэлж дайрна. Тэгэхлээр би дахиад л зовох байх даа? Өвөө яаж бурхан болсон юм бол оо? Өвөө лав Ганданд байхгүй байсан. Ганданд байгаа тэр

бурхнуудын дотор нь ороод суучихсан юм болов уу гэсэн чинь үгүй байсан. Тэр хув хүйтэн чулуун бурхдын аль нэг нь өвөө байсан юм болов уу? Арай л үгүй баймаар юм. Үгүй л байсан даа. Өвөө бурхан болсон ч үнэн л бол яамай даа. Бурханд хүн болгон мөнгө төгрөг өгөөд л. Тэр мөнгө төгрөгөөр бурхнууд яадаг юм бол доо? Жанрайсиг гэдэг тэр том бурхан бол аймаар том сүртэй бас баян бурхан юм. Яасан ч олон жижигхэн бурхад түүнийг тойроод байдаг юм бэ дээ. Тэр жижигхэн бурхдын нэг нь өвөө маань ч байж мэдэх юм. Тэгвэл өвөө маань над шиг ингэж зовж зүдрэлгүй сайхан л байгаа даа” гэж бодож байсан. Хүү тийнхүү бодож, өвчнөө мартчихсан байжээ. Хүүг бодлоо дуусгаж амжаагүй байтал нь тархи, толгой, гар, хөлийнх нь өвчин зүв зүгээр болчихсон. Өлсөхөө ч байчихсан, даарахаа ч байчихсан. Нэг л жаргалтай юм шиг болчихсон.



Хүү учрыг нь ололгүй юу болсныг ойлгох санаатай эргэн тойрноо хартал тэр өөрөө хоёр болчихсон байж. Тэсэхүйеэ бэрх өвдөн үйл тамыг нь цайлгаж байсан зовлонт бие нь тэртээ дор эвдэрхий тоосгон байшингийн цементэн шалан дээр дээшээ хараад ямар ч мэдээ, сөхөөгүй унтаж байжээ. Харин агаарт шувуу мэт хөвөн нисэх нэг бие нь ямар ч дүрсгүй, гар, хөлгүй, үзэгдэх, баригдах юмгүй зүв зүгээр л нэг цэнхэр гэрэл байсан. Хүү өөрийгөө “Зүүдэлж байна даа. Их сонин юм байна” гэж бодсон. Үнэн хэрэг дээрээ энэ нь зүүд биш байсан. Түүнээс хойш хүү ерөөсөө өвдөөгүй, даараагүй, өлсөөгүй билээ. Харин түүнд нохой болох уу, хүн болох уу, аль эсвэл өөр юу ч юм болох уу гэсэн эргэлзээ байнга төрдөг болсон. Хүү тийн хоёр хуваагдаад удтал олон хоногийг өнгөрүүлсэн. Нэг удаа тэр өөрийнхөө өвддөг байсан, өлсдөг байсан биеийг юу болж байгааг харахаар очтол түүний биенээс юу ч үлдээгүй, тэр бие нь хаашаа ч юм алга болчихсон байсан. Хүү тэгэхлээр нь өөрийнхөө тэр биеийг олохоор Улаанбаатарын бүх л байшингуудаар, орц хонгилоор, айл болгоноор орсон. Тэгж явахдаа тэр өвддөг биетэй байхдаа үзээгүй бүх зүйлээ үзсэн. Баян чинээлэг хүмүүст тэр мөнгө гэдэг санасан бүхнээ авч болдог зүйлийг яаж олдог вэ гэдгийг ойлгосон. Хүмүүс ямар өөдгүй байдаг, нохойноос хэд дахин дор байдгийг хүү ойлгосон. Хүмүүс нэг нэгнээ далдуур хичнээн муулдаг, нэг нэгнийхээ мууг үзэхийн тулд яахаас ч буцахгүй байдгийг хараад ухаан жолоогүй айсан. Хүү нэг удаа банкны эзэн эр хүмүүст очих ёстой гадаадаас тусламжаар хүрсэн мөнгийг хэрхэн муу аргаар хуйвалдан авч байгааг хараад “Ийм хүмүүс л бусдынхаа юмыг булаагаад, дээрэмдээд, хулгайлаад авчихдаг болохоор л зарим хүмүүс нь хүн биш амьтан болчихдог юм байна даа” гэдгийг ойлгосон. Хүү тийнхүү айл болгоноор, байшин болгоноор хэрэн хэсч явахдаа хүмүүс яахаараа өвддөг, өлсдөг, бүр амьтан болдгийг харж авсан.

Эцэст нь хүү Улаанбаатараас холгүй орших оршуулгын газар өөрийнх нь биеийг огт танихгүй хүмүүс газарт булахыг хараад “Өө, би яг өвөө шигээ болчихсон байна ш дээ. Өвөөгөө олохгүй байсан чинь хүмүүс өвөөгийн үлдсэн биеийг нь ингээд газарт булчихсан юм байна. Тэгээд л өвдөхгүй, өлсөхгүй болчихсон юм байна. Одоо би нохой болж болох байх. Өвөө маань ингэж байгаад л бурхан болчихсон юм байна даа. Өвөө намайг харж байсан байна шүү” гэж санаад баярласан. Хүү тэгээд нохой болох гэж маш их зовсон, маш их хичээсэн. Хүү нохой болно гэдэг чинь шууд л нохой болохгүй их л юм үзэж, харж байж болдог юм байна даа гэдгийг ухаарсан. Тийнхүү нохой болохын тулд хүү хэсүүчилж яваад хэдэн хүмүүс өвөөгийнх нь ярьж байсан Зориг гэдэг хүнийг муулж, бидний замд саад болох гээд байвал хөнөөх хэрэгтэй гэж ярьж байхыг мэдсэн. Эхлээд хүү “Энэ хүмүүс яагаад тэр сайн хүнийг муулаад байгаа юм бол? Тэр хүн яачихсан юм бол доо?” гэж бодоод учрыг олох гэж хэрэндээ л хичээсэн. Гэтэл тэр хүмүүс түүнийг өвөөгийнх нь хэлснээр “дээш нь гаргахгүйн” тулд тэгж байгааг ярианаас нь олж мэдсэн. Хүү тэгээд С.Зориг гэдэг хүн дээр очоод “Таныг хүмүүс хөнөөх гээд хуйвалдаад байна” хэмээн хэлэх гэтэл өөрөөс нь ямар ч дуу, чимээ гараагүй. Зориг гэдэг хүн ч түүнийг ер олж хараагүй.

Хүү тэгэхлээр “Би одоо хэнд ч харагдахгүй, тэгсэн хэрнээ шувуу шиг нисээд байгаа юм байна. Ерөөсөө хурдхан шиг нохой больё. Нохой болж байгаад түүнд санаагаа ойлгуулъя” гэж нохой болохын тулд дахиад л хүлээж, хичээж гарсан. Тэгж, тэгж байгаад арай чүү нэг юм нохой болсон. Төмөр замын өртөө бараадан тэнэж явдаг нэгэн золбин жингэр гурван гөлөг гаргасан. Эхний хоёр гөлгөнд нь хаа нэгтэйгээс өөртэй нь адилхан үзэгдэх биегүй зүйлс тэр дор нь л цэнхэр дөлөө шингээгээд гөлөг болоод хувирчихсан. Түүний дараа гарсан гөлгөнд хүүгийн бие нэг л сонин часхийсэн өвдөлт аваад үл мэдэг гал улалзуулан

орсон. Хүү тэгээд гөлөг болчихсон. Олон өдөр хүсэн хүлээсэн нохойныхоо амьдралыг тэгж л үзсэн. Хүү түүнээс хойш өөрийгөө нохой гэдэгт итгээд нохой болчихлоо хэмээн бодож байсан боловч үнэн хэрэг дээрээ хүн ч биш, нохой ч биш байх үеийн тэрхүү зовлон, бодол сэтгэлд нь тэр чигээрээ үлдсэн байсан. Эхэндээ хүүг хуцах гэж оролдоход нь дуу нь даанч арчаагүй, дэндүү сул дорой сонсогдож билээ. Хүү тэгэхэд “Би ч азгүй юм даа. Нохой ч болж чадахгүй нь” гэж гуниглангуй бодсон юм. Тэгээд аажмаар дуу нь бүдүүрэн чангарч, хөл, гарт нь бяр сууж хатуужиж эхлэхээр “За даа. Одоо л нэг юм нохой болж санаа амрах нь” хэмээн тайвширсан билээ. Түүний дараа гөлөг мөнөөх аюултай хүмүүс Зориг гэдэг хүнийг хөнөөх гээд байгааг гэнэт санаад ямар ч байсан түүнийг аврах гээд тэднийх рүү шогшин очсон ажээ.

АРВАНХОЁР. ОПЕРАЦИ

Хотын төв дэх тохилог ажлын байрандаа бизнесмэн эр “Ху овогт” хэмээх операци гардан зохион байгуулах эртэй операцийн талаар ярилцахаар яаралтай дуудав. Угийн дуулгавартай Ху овогт эзнийгээ дуудсан даруйд нүд ирмэхийн зуур хүрч ирлээ. Бизнесмэн эр түүнээс “Бүх зүйл жин тан биз дээ? Маргааш чиний хэлснээр эцсийн өдөр шүү дээ. А, Б төлөвлөгөө чинь баараггүй биз дээ? Би саарал ордныхонд бүх ажиллагаа хангалттай бэлтгэгдчихсэн гээд хэлчихсэн. Болно биз дээ?” гэж шавдуулан асуулаа. Ху овогт “Та А төлөвлөгөөний талаар ерөнхийд нь мэдэж байгаа байх. А төлөвлөгөө бол яг л ярьснаараа хийгдэнэ. Өнөөдөр би Бат болох Мөнхөө, Оюун болох Энхтуяа нартай уулзаж, тэдний хийх ажлыг зуун хувь хуваарилж өгнө. Манай хүмүүс тэр хоёрыг сүүлийн хоёр сар гаруйн хугацаанд хяналтдаа байлгасан. Аль аль нь бидний ажлыг гардан хийж чадах хүмүүс гэдэг нь нотлогдсон. Бат болох Мөнхөөг миний баруун гар гэж хэлж болох цагдаагийн нэг офицер надад зааж өгсөн. Өмнө нь нэг бус удаа аллага хийж байсан яахаас ч буцахгүй эр гэж танд хэлж байсныг та санаж байгаа байх. Оюун болох Энхтуяаг ч гэсэн та мэдэж байгаа. Тэр хоёрын аль аль нь л сэтгэлзүйн хувьд бэлтгэлтэй байгаа. Харин би тэдэнд яг хэн гэдэг хүнийг хөнөөлгөх гэж байгаагаа өнөөдөр орой хэлнэ. Өнөө оройноос хойш тэднийг шууд хараандаа авч тусгай газар хяналтдаа байлгана. Тэгээд манай зарим хүмүүсийн тодорхой мэдээллийн дагуу тэднийг тодорхой цагт гаргаж, А төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна. Яг хаана уг операцийг явуулж болохыг тухайн цаг үеийн нөхцөл байдлаас тодорхойлон үйлдүүлнэ. Танд хэлж байснаараа тав дахь өдөр бүх зүйлийг дуусгавар болгоно. А төлөвлөгөөний бүх үйл ажиллагааг би өөрөө хянаж байна. Харин Б төлөвлөгөөнд миний ярьж байсан нөгөөх Хятадын мэргэн бууч оролцоно.

А төлөвлөгөөний ёсоор операцийг гардагчдыгаа би өөрийн биеэр цэвэрлэнэ. А төлөвлөгөө бүтэхгүй бол Б төлөвлөгөө бол шууд буудахаар төлөвлөгдсөн байгаа. Б төлөвлөгөөгөөр хэрэг үйлдэх цэгт асуудал гарвал гардагчдыг ч, гэрчүүдийг ч, операцийн байг ч шууд л мэргэн бууч устгана гэсэн үг юм. Бид урьдчилаад хэргийг үйлдэж болох бүх газруудыг судлаад мэргэн буучаа хаана, хаана байрлуулж болохыг тодорхойлчихсон байгаа” хэмээн эзэндээ хийх ажлынхаа талаар нэг амиар шахуу ярьж дуусав. Бизнесмэн эр “За, болж, болж. Чи ч энэ талаар хангалттай туршлагатай хүн. Би өөр нэг их юм яриад юу хийхэв дээ. Би чамд одоогоор өгөх ёстой мөнгөний чинь гучин хувийг өгсөн гэдгийг чи мэдэж байгаа. Маргааш бүх үйл ажиллагаа болж өнгөрсний дараа ахиад гучин хувийг чинь өгнө. Үлдсэнийг нь гардагчдыгаа цэвэрлэсний чинь дараа өгнө. Болно биз дээ? Шударга биз дээ?” хэмээн өгүүлэв. Ху овогт “Тэгэлгүй яахав. Би чинь хүнд итгэвэл итгэсэн шиг итгэдэг. Хүн итгэл алдвал өширхсөн шиг өширхдөг хүн дээ” хэмээн өгүүллээ.

Энэ нь “Чи надад хэлснээрээ байхгүй бол өөрийг чинь ч яаж ч чадна шүү” гэсэн далд санаа байлаа. Бизнесмэн эр түүний яриаг огт сонсоогүй юм шиг хар, цагаан дуугүй байснаа “Маргааш болтол баяртай. Маргааш холбоо барина биз дээ. Би юу болохыг хүлээгээд л сууж байя” гээд суудлаасаа өндийв. Ху овогт түүний үгний хариуд “Тэгэлгүй яахав. Маргааш уулзъя” гэснээ баяртай ч гэлгүй өрөөнөөс нь гарч одов. Бизнесмэн эр “Энэ ч зэвүүн эр дээ. Иймэрхүү хүн амьтдаас аль болохоор л хөндий байвал сайнсан. Даанч яаж ч болдоггүй юм гэж байх юм даа. За, яахав. Энэ удаа энэ нөхөр миний хүслийг биелүүлчихвэл болох нь тэр. Дараа нь яахав, учрыг нь олчихож болно биз. Эвгүйтвэл энэ эр манийгаа ч цааш нь харуулчихаж мэдэх амьтан шүү” хэмээн шүд зуун бодов. Бизнесмэн эрийн итгэл, зүтгэл хоёрыг нэг зэрэг төрүүлж буй энэхүү Ху овогт гэгч эр цагийн сайханд хүчний байгууллагад нөлөө бүхий ажил эрхэлж байсан хүн юм. Мөн л ардчиллын салхинд эрх ямба бүхий суудал, олз омогноосоо салсан тэрбээр бүгдийг үзэн ядалтын харцаар харж, үзэн ядалтынхаа бай болгож, хэн нэгний амь амьдралыг бусниулан бусдын цус, нулимсаар жаргал хийж яваа нэгэн билээ. Түүний араатан шинж төрхийг олж анзаарсан улс төр, эдийн засгийн далд бүлэглэлийнхэн шуналын оч үсэргэн нүдэнд нь цус ханхалсан мөнгө харуулж, өөрсдийнхөө замд саад болж буй бүхнийг зайлуулдаг болсон юм.

АРВАНГУРАВ. ШИЙДВЭР

Зоригийг өглөө гэрээсээ гарахад нь аанай л мөнөөх зовлонт гөлөг сүүлээ шарвалзуулан хөлийг нь ороон угтав. Зориг “Үгүй, энэ муу амьтны байж байгааг. Зайлуул даа” хэмээн нэг л анзааргагүй өгүүлснээ машиндаа суун хаалгыг нь тархийтэл хаалаа. Тэрбээр орцных нь үүдийг манах гөлгийг яах гээд байгааг анзаарах нь бүү хэл жолоочоо хэрхэн өөртэй нь мэндэлж байгааг ч анзаарсангүй. Зөвхөн түүний бодол, сэтгэлд “Ерөнхий сайдад нэр дэвшвэл олонхийн дэмжлэгийг авч чадах болов уу, яах бол?” гэсэн эргэлзээ тасралтгүй төрж байлаа. “Хэрэв олонхийн дэмжлэг авч чадахгүй бол нэг нэр, хоёр хоч зүүх л болно. “Энэ шар Зориг Ерөнхий сайд болж чадахгүй гэдгээ мэдсээр байж юун ч албан тушаалд дуртай золигов дээ. Түүнийг олонхи яаж дэмжих юм бэ? Ёстой бүтэхгүй байсан нь эхнээсээ тодорхой байсан юм” гээд л хэн хүнгүй тавлацгаах болно. Дээр нь нам доторх эрх ашиг, амбийц хөөсөн жижиг бүлэглэлүүдийн зөрчил улам үүснэ. Энэ Зориг фракц, бүлэглэлүүдийн эв нэгдлийг сахиулах нь бүү хэл бүр бусниулаад хаячихлаа гэгцгээх болно. Тийм болохоор өнөөдөр зарим нэг хүмүүстэй уулзаж, санал бодлоо солилцъя. Н.Багабанди Ерөнхийлөгч ер нь ямар бодолтой байгаа юм бол? Намайг Ерөнхийлөгч дэмжихгүй гэвэл тэгж цаг алдах, бусдын ажлыг хүндрүүлэх шаардлага ч байхгүй. Ерөнхийлөгч ямар нэгэн дарамт шахалт үзүүлэлгүй дэмжвэл олонхийн дэмжлэгийг авч магадгүй юм.

Гэхдээ хувь хүмүүсийн амбийц ингэтлээ хөдөлчихсөн байгаа энэ үед олонхийн дэмжлэг авна гэдэг бол бас л хүнд зүйл. МАХН-ын дийлэнх гишүүд намайг дэмжихгүй нь тодорхой. За, яахав. Ганц нэг гишүүдтэй нь биечлэн уулзаж, ярилцвал байдал арай өөр болж магадгүй л юм. Социал демократууд намайг ерөнхийдөө л дэмжихгүй байх. МҮАН-аас биш МСДН-аас Ерөнхий сайдтай болохыг тэд хүсч байж болох талтай. Тийм бол манай намынхныг Ерөнхий сайдад нэр дэвших тохиолдол болгонд л соц-декүүд сөрөг товч дараад байна гэсэн үг. МАХН-ынхан бол угаасаа дараагийн сонгуулийг тэвчээртэй хүлээж чадахгүй, улс төрийн алдагдсан эрх мэдлийнхээ төлөө юу ч хийхээс буцахгүй байгаа хүмүүс. Хүн гээч амьтан албан тушаалд ямар их дуртай байдаг юм бэ дээ. Тэр

албан тушаалаа алдчихаар хэрхэн байж ядаж байдгийг МАХН-аас зарим албан тушаалтнууд харуулж байна. Харин Зэнээ гуай, Дашбалбар мэтийн шударга гишүүд намайг дэмжих л байх. Юутай ч гэсэн зарим хүмүүстэй Ерөнхий сайдад нэр дэвших тухай асуудлаа ярьж байз. Тэгээд олонхийн саналыг авахаар байвал Ерөнхий сайдад нэр дэвшиж болох юм гэдгээ албан ёсоор хэлж байз” хэмээн бодож байлаа. Түүнийг ийнхүү нэг их бодолд дарагдсан аятай явахыг анзаарсан жолооч нь хаашаа явахыг нь асууж төвдөлгүй хотын төв рүү чиглэн алгуурхан явж байлаа.

АРВАНДӨРӨВ. ЗОВЛОН

Нохой болдог хүү нохой болохынхоо өмнө бусадтай адилхан хүмүүсийн дунд дуулж ч, тоглож ч үзээгүй юм. Бас хүүхдүүдтэй адилхан гоё хувцаслагчааад сүлд модны наадам дээр ч юм уу хаа нэгтээ ганц удаа ч атугай дуулж, бүжиглэж байсангүй. Аанай л гав ганцаараа өлсч, чичрэхийн зовлонг эдлэж ахуйдаа

“Элэг зүрхнээс уяатай

Энхрий Монгол нутаг минь

Эцэг, эхээс заяатай

Эрдэний алтан өлгий еэ” хэмээн дуулдаг байсан. Тэгж дуулж үзэх ахуйд нь өөрийн эрхгүй хоёр нүднийх нь нулимс асгардаг байсан. Түүнд “Халуун элгэн нутаг” хэмээх тэр дууг дуулахаар нэг л жигтэй хачин гуниг төрдөг байсан. Түүний хувьд халуун элгэн нутаг нь нэг их сүрлэг уулс, хаврын зөөлөн салхи, уудам шаргал тал, намрын зэрэглээ, зуны цэцэгс байгаагүй юм. Аль ч үед тэрээр тэр бүхнийг тэгтлээ дээдлэн сэтгэл зүрхээ огшоож байсангүй. Зүгээр л тэр дууг дуулахаар цээжинд нь гоц гойд юм мэдэгдэхгүй хэрнээ овоороод байгаа бөөн хар дарамтаа түр зуур аваад хаячихаж байгаа юм шиг болдог байсан ажээ. Түүнд “Халуун элгэн нутаг” дууны аялгуу хэзээ ч дахин уулзахгүй өвөөг нь, хэзээ ч уулзаж байгаагүй ээжийг нь авчирч өгөн бүхий л энэлэн шаналанг нь нимгэлэх шиг болдог байсан юм. Нохой болсноосоо хойш тэр хүний амьдралд байхдаа эдэлж байсан хамаг л зовлонгоо орхисон гэвэл худлаа болно. Тэр өвөөгөө ч бас ээжийгээ ч мартаагүй. Хүний амьдралаар амьдарч байсан бүх л зовлонгоо мартаагүй. Тийм болохоор түүнд хааяа бас дуулах хүсэл төрж байв. Гэвч дуулж даанч болохгүй. Нохой хуцна уу гэхээс дуулна гэж байхгүй. Ярьж чадахгүй байж дуулж чадна гэж ер байхгүй. Нохой ч бас хүсэл, сэтгэлтэй байдаг агаад тэр хүслээ дарахын тулд дуулахыг хүсдэг гэдгийг зөвхөн тэр л ийнхүү мэдэрсэн юм. Тэрээр хүн зөөврийн тэрэгнүүд дундуур хайвагнан шогшсоор Тээврийн товчооны зүүн урд үзүүрт нэгэн ногоон өнгөтэй ТҮЦ-ний дэргэд очлоо. Тэрхүү ТҮЦ-ний эзэн намхан шар авгайг тэр сайн мэдэх юм. Хүний амьдралаар амьдарч байхад нь тэр авгай түүнийг нэг өдөр хулгайд сэрдэж баллах шахаж билээ. Хоёр муу нимгэн сарьснаас нь угзчин зулгааж, “Өдрийн орлогын маань хэдэн төгрөгийг хулгайлчихлаа” гээд нэг л их сүр бадруулан цагдаагийн газар аваачиж өгсөн юм.

Харин түүний хувьд аз тохион хүнлэг байрын цагдаа залуу таарч, яг хулгайлсан уу, үгүй юу гэдгийг нь нухацтайхан асууж байснаа гэм буруугүй гэдгийг нь мэдээд тавьж явуулсан юм. Ямар ч буруугүй байж тийнхүү хулгайд сэрдэгдсэндээ тэр маш их гутарч байсан.

Гэлээ гээд яахав дээ, өнөөх хүмүүсийн ярьдаг шорон гэдэг аймаар юм руу нь авч яваагүй болохоор нь үг дуугүй баярлаад л арилж өгсөн хэрэг. Түүнээс хойш тэрээр тэдний ТҮЦ-ний орчмоор явахаасаа ухаан жолоогүй айдаг болсон юм. Харин нохой болсноосоо хойш нэг өдөр хий дэмий тэнэж яваад тэдний ТҮЦ-ний хажуугаар гартал мөнөөх гайтай авгай “Гөлөөг, май, май” гээд л учиргүй хэдэн хуушуурын үлдэгдэл шидэж өгсөн юм. Мах нь жаахан муудсан болохоос биш уул нь гайгүй амттай тэр хэдийг нь үмхэж орхисон. Түүнээс хойш тэрээр амтшин тэдний ТҮЦ-ний хажуугаар хааяа эргэлддэг болсон юм. Авгай ч гэсэндээ нэг их гавихгүй ч үе үехэн түүнд хоолны шавхруу шидэж өгдөг байв. Харин нэг удаа авгай, гөлөг хоёрын ганзага нийлж гайгүй наймаа хийчих шахсан юм. Яагаад вэ гэвэл хөдөөний байрын нэгэн өвгөжөөр эр тэдний ТҮЦ-д нэг өдөр хэдэн хуушуур идээд сууж байхад нь гөлөг аанай л шавхруу горьдон тэр хавиар эргэлдсэн юм. Тэгтэл авгай гөлгөнд хуушуурын хэдэн шавхруу шидэж өгсөнөө юу болсон юм, гэнэт л өнөө хүнд хандан “Та манай энэ гөлгийг хөдөө рүүгээ аваад явахгүй юм уу? Уул нь сайн нохойны гөлөг байгаа юм. Таныг авна гэвэл ганц хоёр мянган төгрөгөөр өглөө” хэмээн юу ч болоогүй юм шиг гөрж орхисон юм.

Өвгөн авгайн үгийг дув дуугүй сонсон хоолоо идсэнийхээ дараа тостой гараа арчсан төдий болчихоод гөлгийг барьж аван шилэн хүзүүн дээрээс нь, сүүлнээс нь хэдэнтээ өргөж үзсэн. Гөлөг хамаг арьс нь хуурах шахан тэсэхийн аргагүй өвдөж байсан ч өнөө л хүний амьдралд байхдаа мөрөөдөж байсан тэжээвэр нохойнхоо амьдралаар одоо л нэг амьдрах нь гээд бүхнийг тэсч час ч гэж гаслаагүй юм. Өвгөн тийнхүү хэдэнтээ гөлгийг шалгасныхаа дараа аман дотроо “Гайгүй л нохой болох бололтой юм” гэж үглэснээ авгайд хандан “За, тэгээд энэ гөлгийг чинь хэдэн төгрөгөөр авах болж байна?” хэмээн асуусан аж. Авгай наймаачин ухаан зааж “Би ямар нохойн наймаачин биш та өөрөө л мэдэхгүй юу” гэж өгүүлсэн юм. Өвгөн авгайд хандан “Хүүхээ, би таван мянган төгрөгөөр авчихъя гэж бодож байна” хэмээхэд авгай мөнөөх л наймаачин үржүүлэх ухаанаараа “Бусдыг нь арван мянган төгрөгөөр манай хүүхдүүд зарчихсан байсан. Уул нь наадхи чинь цээжний гөлөг нь байхгүй юу. Таныг яахав хөдөөний хүн болохоор би хямдхан өгч байгаа юм. Та яахав, найман мянган төгрөгөөр ав” хэмээжүхүй. Өвгөн авгайн үгийг ухаж байгаа янзтай хэдэнтээ гансран гөлөгний толгойг хий дэмий тонгочуулснаа үг дуугүйхэн өврөө ухан учиргүй их баадагнан боосон түрийвч дотроосоо гар зүсэм найман мянган төгрөг гарган авгайд сарвайснаа гэнэт нэгийг санав бололтой гөлгийг дахин барьж авснаа дээш нь өргөн эргүүлж үзээд “Өө, солиг. Энэ чинь охин гөлөг байхчинав” гээд наймаагаа буцааж орхисон аж. Авгай зүв зүгээр байгаад орж ирсэн олзоо буцааж гаргахгүйн тулд бүр хэдэнтээ хямдруулсан боловч зөрүүд өвгөн “Малын дэргэд охин нохой дэмий. Манай хөдөөд мал үржүүлдгээс нохой үржүүлдэггүй. Наад гөлгийг чинь зүгээр өгсөн ч авахгүй” гээд нударга хаялан явж одсон юм. Түүнээс хойш гөлөг бас нохой болоход, өөрийнх нь хүссэнээр айлын тэжээвэр нохой болоход заавал эр нохой болж төрөх хэрэгтэй юм байна даа гэж харуусан бодсон ажгуу.

Арвантав. Түгшүүр

Мөнхөө болзооноосоо арваад минутын өмнө хүрч ирээд орчин тойрноо ажигласхийн суув. Хаа нэгхэн л хүн амьтан орж, гарах жижигхэн бааранд Барууны уянгын дуу бүдэгхэн эгшиглэхийг эс тооцвол түүнд саад болох зүйл өчүүхэн ч байсангүй. Хотын төвд хэрнээ зориуд бололтойгоор олны хөлөөс зайдуу байрлал сонгосон тэр баарыг баргийн хүн эс анзаарах аж. Ху овогт яагаад заавал энэ баарыг сонгосон юм бол доо. Тэр зиндааны хүмүүс уул нь их л баян, тансгаа харуулах гэж аль үнэтэйг нь шилдэг биз дээ. Мань эр ч аргагүй л нохой хүн юм. Дотроо их л нарийн тооцоо гаргаж дээ. Бодвол бүх зүйлийг өөрийн хяналтдаа байлгаж байгаа биз. Магадгүй, одоо намайг хаа нэгтэйгээс ажиглаж ч байж мэдэх юм. Ху овогтын надад өгсөн тэр мөнгө нь урьдчилгааны зөвхөн хорин хувь гэж байгаа. Энэ мөнгийг нь аваад



зугтчихад ч хэсэгтээ л тав арван цаасны проблемгүй гэсэн үг. Даанч энэ цагаан гартнууд тав алхуулахгүй л дээ. Яаж ийж байгаад ямар нэгэн шалтаг гаргаад бариад авна. Нэг барьчихвал хоёр, гурван шанаа өгөөд салах улс биш, яс махыг минь хоёр хэсэг хуваагаад ч санаа нь амрахгүй. Алчихсан хойноо ч адил төстэй улсыг барьж аван эрүүдүүлээд амар заяаг нь үзүүлэхгүй байж мэдэх л юм.

Одоо бол өнгөрсөн. Чигээрээ л цэвэрхэн шиг хийчихээд салъя. Таван цаастай болсон байхад жаахан зугаацах боломж байна гэсэн үг. Холхон л явж ясаа амраая. Энэ монгол хүүхнүүдийн хормой султайг хэлэхийн биш. Хэдхэн улаан мөнгө харуулчих юм бол нөхөр, хүүхэд энэ тэр нь хамаагүй юм шиг байгаа юм. Үгүй, ер нь тэгээд мөнгө харсан хормой султай хүүхнүүдтэй нөхцөхөд ямар ч амт алга юм. Өчигдрийн тэр хүүхнийг байж байгааг нь. Уйлж, дуулж маяглаад л их жүжиг тавьж байгааг нь харахгүй юу. Би тэр хүүхэнтэй тэгээд л өдөр, шөнөгүй нөхцөөд ам руу нь архи дарс, чихэр жимс цутгаад байх юм гэнэ.

Ёстой горьдсоных нь хохь. Гай л байна. Тэр зэргийн хүүхэнд Мөнхөө ашиглуулдаг толгой

биш. Харж л байгаарай. Үгүй, тэр намайг мөнгө төгрөггүй ядаж явахыг харах юм бол нэг нүдээрээ үзнэ гэж байхгүй л дээ. Түүнийг бодохоор тэр муу хүүхний амийг гарзадчихмаар байх юм. Даанч сохор улаан зоосны ашиггүй юм даа. Мөнхөө бол Мөнхөө. Тэр зэргийн юманд хөдөлж гэнэдэхгүй. Харин энэ Ху овогтын захиалгыг л нэг толгой өвдчихгүй хийчихмээр байх юм. Эд нар ер нь яг юу хийлгэх гээд байгаагаа ч тодорхой хэлэхгүй юм. Нэг л сонжоод, сожоод байх шиг байна аа даа. Иймэрхүү юм чинь бас л тамтай юм. Ху овогттой түс тас ярина аа. Тэгэхгүй бол энэ янзаараа бүтэхгүй бололтой. Ингэж байгаад ер нь тэр муу хошуучийг нэг тийш нь зайлуулахгүй бол насаараа ингээд л дарамтлуулахаар байна шүү. Ху овогтын энэ ажил дууссаны дараа тэгж байгаад хошуучтай тооцоо бодно оо. Мөнхөөг толгойгоо гашилган сууж байтал бармен залуу үүдээ дотроос нь түгжээд хөшгөө буулгаснаа Мөнхөөд хандан “Таны хүлээж байгаа хүн одоохон ирнэ” гээд бүхээгнийхээ хаалгаар цааш нэвт орон арилж одов. Баарны бүдэг гэрэлд тамхи улалзуулан гайхшран сууж байсан Мөнхөө бараг л цочсондоо босон харайсангүй. Юу гэвэл гэв гэнэт түүний чанх өмнөх хана ямар ч чимээ аниргүйгээр хаалга болон нээгдэж, цаанаас нь Ху овогтын ёозгүй хүйтэн царай цухуйх нь тэр. Цочно гэдэг хүн алахаас аймшигтай байдаг чинээ Мөнхөө бодож байсангүй. Тэгэхдээ зүгээр л нэг гэнэт чимээ сонсох ч юм уу хэн нэгэн зориудаар цочоохоос тэс өөр ер байж боломгүй байдлаар Мөнхөө цочжээ. Ямар ч өө сэвгүй, өчүүхэн зураас төдий ч байхгүй обойдсон хана хаалга болоод гэнэт онгойх нь чинээ төсөөлж байсангүй. Тийм болоод л тэрбээр барьц алдан зүрх нь огшсон хэрэг. Мөнхөөгийн ийн адган цочиж байгааг хараад Ху овогтын нүүрэнд ямар ч хувирал бий болсонгүй. Ху овогт Мөнхөөтэй толгой дохисонгүй. Зүгээр л дув дуугүйхэн гараараа “Нааш ир” хэмээн мөнөөх ханан хаалгатай өрөө рүүгээ дохив.

Мөнхөө Ху овогтыг даган үл үзэгдэгч хаалгатай тэрхүү нууц өрөөнд нь орлоо. Уртаашаа гурван метр гаруй, өргөөшөө хоёр метр орчим тэр өрөөнд хүнд хэрэгтэй бүх л зүйл бараг байх шиг байв. Хана руугаа босгоод налуулчихдаг диван, бичгийн ширээ, номын тавиур, бяцхан хоолны ширээ, автомат, макарь, сэлэм, сүх, хутга, тэсрэх бөмбөгний гэр гээд л гол төлөв зэвсэгний цуглуулга нь юун түүрүүнд нүдэнд нь тусав. Ху овогт Мөнхөөг бичгийн ширээнийхээ хажуугийн мухар сандал дээр суулгаад нэгэн хэмээр яриагаа эхлэв. “Ярьснаараа өнөөдөр бүхнийг хийх төлөвлөгөөтэй байна. Чамд манай нэг хүн тусална. Тэр мөдхөн ирнэ. Түүнийг иртэл чамд эндээ байсан нь дээр байлгүй. Бид урьдчилаад та нарын явах, үйлдэх бүх маршрутыг тогтоочихсон байгаа. Яг үйл ажиллагаагаа хийх газар чинь гэвэл тохиромжтойн хувьд хоёр газар байгаа. Аль алиныг нь бид хэд хоногийн өмнөөс судлаад хараандаа оруулчихсан байгаа. Эндээс тийм ч хол биш. Ерөөсөө бүх ажлыг арваас хорин минутын дотор багтаана. Та нарын явах зам бол маш тодорхой. Очихдоо эндээс машинаар явна. Буцахдаа харин таксигаар явна. Бид такси олоод гарах зам дээр чинь байлгаж байна. Тэр таксигаар та нар гол замд хүрээд бидний бэлдсэн машинд сэлгэж сууна. Бүх зүйл гэрэл дохиог хүртэл оруулаад бидний тооцоолсноор 20 минутад багтаж байгаа. Та нар хугацаандаа гол зам дээр бидний машинд хүрч ирвэл ямар ч аюулгүй боллоо гэсэн үг. Маршрутын хувьд ийм байна. Одоо гол зүйл рүүгээ оръё. Үйлдлийг чи туршлагатай хүний хувьд шууд гардаж хийнэ. Аль болохоор чимээ багатай, олны анхаарлыг татахгүйгээр хийх ёстой. Тийм учир буу хэрэглэхгүй гараараа үйлдэнэ. Аль болохоор богино хугацаанд найдвартай хийх ёстой. Хүч хүрэхгүй гэсэн зүйл байхгүй биз. Чамтай хамт ажиллах хүн чинь бас л мэргэшсэн хүн байгаа. Үйлдэл хийж болохуйц хоёр газрын нарийвчилсан зураг энэ байна. Чи сайн хараад ав”. Ху овогтын ийн ярихыг сонсоод Мөнхөөд нэгэн далдын түгшүүр өөрийн эрхгүй төрж эхлэв.

Мөнхөө өөрийнхөө хэлдгээр ан хийж хэдэнтээ үзсэн. Хүн алахаас бол айхаас нэгэнт больсон хүн. Гэлээ гэхдээ ийм тодорхой, нарийн нууцлаг төлөвлөгөөтэйгээр хүн алдаг тухай бол зөвхөн киноноос үзэж байсан. Тэр айхтар мафи энэ тэр нь хөгжсөн гадаад орнуудад л тийм нарийн аргаар хүн алдаг байх гэж бодож байснаас Монголд ийм юм байна гэж бодож, зүүдэлж үзсэнгүй. Тэгтэл тэр нь Монголд байдгаар барахгүй өөрөө кинонд гардаг шиг захиалгат алуурчин болоод байгаагаа ойлгоод айх шиг, гайхах шиг болж байлаа. Мөнхөө ан хийхдээ ингэж нарийн төлөвлөж байгаагүй, зүгээр сайн бодож, анаж байгаад л сиймхийг нь тааруулаад хийчихдэг. Тийм болохоор ингэтлээ газрын зураг мураг болоод хөрөнгө мөнгө үрээд байгаагүй. Энэ бүхнийг нь бодохоор Ху овогтын захиалаад байгаа тэр хүн нь их л том гарын амьтан байж таарах нь дээ. Тэр арай ч ийм болно гэж бодсонгүй. Түүнийг тийн бодтол түрүүний цочсон цочроо нь сэргэж, дээр нь бас айдас нөмөрлөж эхлэв.

Мөнхөө “Ингэхэд би чинь таван цаас олох гэсэн биш бүр ингээд Ху овогт энэ тэрийн гарт өөрөө явж ирээд орчихож байгаа юм биш үү? Эд нар надад мөнгө өгөөд зүгээр сална гэж байх уу. Мэдээж үгүй. Хэргийнхээ мөрийг баллах гээд л намайг арчиж таарна. Нэг ёсондоо би золиосны хүн болж, эд нарын гарт алагдана гэсэн үг. Тэр муу хошуучийг санал тавихад нь “За, тэгье” гэхихээд арилж өгдөг байж. Хожим нь ямар нэгэн шалтаг заагаад аргалж болох л байсан даа. Ер нь ч тэгээд тэр хошууч намайг илрүүлчихээд дарамтлаад байхад би балай хүн шиг тэрүүний аясаар байгаад байдаг. Дүүрчихсэн юм. Хошуучийн учрыг л хурдхан олох хэрэгтэй байж дээ. Одоо ч надад буцах газар алга. Эд нарын үгийг дагаж, хий гэснийг нь хийчихээд хэдэн цаасаа аваад өнөө шөнөдөө багтаад арилж өгье. Тэгэхгүй бол тэд яаж ч мэднэ шүү. Бодоод байхад хэдэн цаасныхаа тохирсон хувийг Ху овогтоос одоо л авъя”.

Мөнхөөг ийн бодож байтал Ху овогт бодлыг нь таасан юм шиг. “Чиний авах ёстой 30 хувь энэ байна” гээд боодолтой мөнгө сарвайснаа “Үлдэгдлийг нь орой операци дууссаны дараа өгнө” гэж өгүүлээд цагаа харж, “Чиний хамтрагч ирэх болж байна даа” гэж үргэлжлүүлэн гүвтнэв. Ху овогтын яриа дуусахтай зэрэгцэн нууц өрөөний хаа нэгтээ хонхны дуу бүдэгхэн жингэнэв. Бүх л зүйл нь нарийн зохион байгуулагдсан энэхүү түгшүүрт орчинд Мөнхөө нэг үеэ бодвол овоо дасч эхлэв. Хэдэн төгрөгнийхөө барааг хараад түүнд тайвшрахын зэрэгцээ баруун сугандаа нууж сойсон гар буу нь мэдрэгдэхэд цээжинд нь бас нэгэн омог төрж, “Эд нар новширвол би ч бас новширно доо” хэмээн зүрх нь бага зэрэг овозож байв.

Арванзургаа. Атаа

Ажлын цаг тарахаас даруй тавиад минутын өмнө гэртээ ирсэн буурал толгойт эр гал тогооныхоо ширээн дээр өдөр тутмын сонинууд болон шинээр хэвлэгдсэн шар хэвлэлүүдийг гарчиглаж суув. “Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Элбэгдорж шинээр Засгийн газар бүрдүүлэхийг нэг их хүсэхгүй байна. Тавин хэдхэн хоног Ерөнхий сайд байсан түүнд өндөр албан тушаалынхаа сэнтийг өөр хүнд хүлээлгэж өгөх нэг их таатай биш байгаа бололтой”, “Ерөнхийлөгч Н.Багабандид Э.Бат-Үүлийг Ерөнхий сайдад нэр дэвшихэд нь “Голомт” банкиг шалгасан шалгалтын үр дүнгээс шалтгаалаад гэсэн шалтгаанаар татгалзжээ”, “”Ардчилсан холбоо” эвслийн удирдлага дахь хямрал энэ янзаараа цааш үргэлжлэх янзтай байна”, “МҮАН-аас одоо Ерөнхий сайдад нэр дэвшээд

амжилт олж болохуйц хүн ганцхан С.Зориг л үлджээ. Эвсэл дотроо болон сөрөг хүчнийхэн дунд ч нэр хүнд нь төдийлөн унаагүй тэрбээр энэ удаа МҮАН-ын аврагчаар тодорч магадгүй юм. Ардчилсан холбоо эвсэл доторх фракциудын зөрчлийг өдөөхгүй, дэврээхгүй хүн бол С.Зориг л гэдгийг ардчиллагчид, ардчиллынхан тооцож байгаа нь тодорхой”, “Хөдөөгийн гэгддэг фракцийн толгойлогч До.Ганболдыг Ерөнхий сайдад нэр дэвшвэл ноён Ерөнхийлөгч хоёр удаа гараа өргөөд дэмжинэ гэж ажиглагчид үзэж байна” гэх зэрэг мэдээллийн гэхээсээ хов живын чанартай зүйлсийг тэрбээр ихэд нухацтай уншлаа. Буурал толгойтын нэг өвөрмөц чанар бол аливаа юмыг хоёр талаас нь хардаг зуршилтай юм. Тэр өдөр тутмын сонингуудаас илүү шар хэвлэлүүдийг чухалчилдаг хүн. Түүнийхээр бол өдөр тутмын хэвлэлүүд хэв ёсны, мэдээжийн болоод өнгөрч буй мэдээллийг нийтэлдэг бол шар хэвлэлүүд болзошгүй болоод аль болохоор далдлагдсан мэдээллийг нийтэлдэг юм.

Энэ чанараараа түүнд өдөр тутмын гэдгээсээ илүүтэйгээр шар хэвлэлүүдийн мэдээ ач холбогдлоо өгдөг билээ. Тэр тусмаа шар хэвлэлүүдэд гарч буй эрх мэдэлтнүүдийн салсан, нийлсэн авгай, хүүхнүүдийнх нь яриа бол түүнд шар тостой боов л гэсэн үг. Солиотой, мэдрэл муутай юм шиг тэр жигтэй ярианууд дотроос ашиглаж болох, сонирхож буй эрх мэдэлтнийх нь эмзэг газар руу нь цохилт өгч болох мэдээлүүдийг тэр хангалттай олдог юм. Буурал толгойтыг тийнхүү шар хэвлэлүүдийн хуудас эргүүлж, цадсан муур шиг тухалж суухад нь ханан пийшин дээр тавьсан тогоотой хоол нь тавиураа оволзуулан буцалж оргив. Буурал толгойт уншиж байсан сонингоо хойш тавиад тогоотой хоолоо янзлахаар очив. Тогоон дотор гурван зэрэг хонины битүү толгой, том томоор нь хэрчээд хийсэн гүзээ халуун галын хүчинд үл ялиг хөдлөн буцална. Харахад ядуухан айлын арга ядсан хоол шиг энэ борогхон хоол бол Буурал толгойтын хувьд хамгийн тансаг хоол нь юм. Түүний энэ хоолыг хэр баргийн хүн тоохгүй, ямбандаа ханасан авгай, хүүхнүүд нь бол бүр ч тоохгүй. Буурал толгойт ч тэднийг дураараа болцгоог гээд нэг их тоолгох гээд учирлаад, сурталчилаад байдаггүй юм. Бүхэл бүтэн улсын мөнгөний эргэлтийн дөч гаруй хувийг барьж буй энэ хүнийг хонины үстэй гүзээ, хуйхалсан толгой өөрөө чанаж идэж байгааг харсан хүний хоёр нүд бүлтэрч магадгүй юм. Харин яагаад заавал өөрөө энэ бүхнийг өөрийн гараараа чанаж иддэгийн учрыг мэдэх юм бол бас л гайхаж шогширох нь зүйн хэрэг юм. Учир нь, буурал толгойтын хүүхэд нас тийм ч сайхан байгаагүй билээ. Дан бүрээстэй умгар гэрт зүдүүхэн өссөн түүнд амьдралын мөн чанарын тухай ойлголт аль эртнээс бүр арван хоёр, гурван настай байхаас нь төлөвшсөн байжээ.

Хөдөө буйдхан өсч торнисон түүнд хорвоо тийм ч зөөлхөн хандаагүй. Ах ч үгүй, эгч ч үгүй, эцэг ч үгүй түүнийг хавьтсан болгон дээрэлхэж байсан. Ядуу, зүдүүгээр нь үргэлж л дуудаж, шоолж байсан. Идэш хийсэн айлын өвдөл, цөвдөлхөн цуглуулж, хоол залгуулдаг эхийг нь хүүхдүүд гуйлгачин, түүлгэчнээр дуудах болгонд тэр амьд голтой бүхэнд өширхдөг болсон юм. Тэгээд нэг удаа эхээсээ “Манайх дандаа л гэдэс гүзээ л идэх юм. Өөр айлууд шиг бүхэл мах, зах чанаж болдоггүй юм уу?” гэж асуухад эх нь “Хошш, чи байтлаа хоол голох нь уу? Би чамайг тэжээх гэж ядаж л байна. Энэ хонины гүзээ, толгой чинь тийм муу хоол биш. Чанар чансаагаараа бол махнаас хамаагүй дээр. Энэ тухай бүр эртний домог ч байдаг юм” гээд нэгэн домог ярьж өгсөн юм. Тэр домогт “Эрт үед нэгэн эр өөрийн эх болон эхнэр, хадам эхтэйгээ амьдарч байжээ. Тэгтэл ноёны зарлиг ирж, залуу эр урт хугацаагаар холын аянд явах болж. Залуу эр “Намайг хол яваад өгөхлөөр манай эхнэр, эхтэйгээ нийлээд ядарсан муу ээжийг минь ад үзэх нь гарцаагүй. Ядарч зүдрэхээр нь аяга

халуун шөл хийж өгөхийн оронд аль болохоор л хурдан үхүүлэхийг бодно биз. Яая даа, байз” гэж шөнийн турш бодож байгаад эцэст нь явахдаа эхнэртээ хандан “За, эхнээр. Чи хоёрын хоёр насан өндөр гарсан хүнийг асрах гэж зүдрэх биз. Манай ээж ер нь ч тэгээд хоногийн тоо нь гүйцэж байгаа хүн. Чи өргөж тэтгэх гээд байхын ч хэрэггүй. Яахав, хоол хийхдээ үл буцлах талд нь үстэй гүзээ хийгээд л өгөөд байхгүй юу. Тэгж байгаад наад хөгшин чинь тааваараа бурхан болно биз” хэмээгээд аян замдаа гарч оджээ. Эхнэр нь ч нөхрийнхөө хэлснээр хадам эхдээ үл буцлах талд нь үстэй гүзээ чанаж өгөөд л байж. Урт аянд залуу эр явж явж байгаад эхдээ санаа зовон зовон иртэл эх нь санаснаас хавьгүй илүү өнгө орчихсон байж. Харин хадам эх нь бүр л эцэж, цонхийсон нь анзаарагдахаар болсон байж. Залуу эр энэ бүхний учрыг мэдсэн хэрнээ эхнэрээсээ “Чи манай эхийг сайн сайхан байлгаж дээ. Их л шөл усаар тэтгэж дээ?” хэмээн асуухад эхнэр нь “Өө, ерөөсөө шөл ус өгөөгүй. Чиний хэлснээр үл буцлах талд нь үстэй гүзээ л чанаж өгөөд байсан” хэмээжээ” гэж өгүүлдэг юм. Энэ домгийн учрыг Буурал толгойт сайн ойлголгүй эхээсээ асуутал нь “Хоол буцалж байгаа газар шим шүүс нь байдаггүй, буцлаагүй газар руугаа тунарчихдаг юм. Тийм болохоор үл буцлах талд нь байгаа гүзээ тэр хоолны хамаг шим шүүсийг өөртөө шингээчихдэг юм” хэмээн тайлбарласан юм. Буурал толгойт үүнээс хойш гүзээ идэх учиргүй дуртай болчихсон хэрэг. Тэр тусмаа нас ахиад ирэхлээр эхийнхээ ярьсан тэр домгийг санаж, үргэлж хүч тамираа алдаж явахгүйн тулд хонины битүү толгойн үл буцлах талд хонины гүзээ чанаж иддэг болсон юм. Санааг нь дагаад ч тэр юм уу хонины битүү толгойн үл буцлах талд хонины гүзээ идээд байхаар залуу цагийнх шигээ огт ядрахгүй байгаа юм шиг л түүнд санагддаг аж. Буурал толгойт нас ахиад ирэхийн үедээ хонины гүзээ идэх дуртай болсноос гадна хамгийн чухал нь үл буцлах талын тухай онол нээсэн юм. Тэр “Үл буцлах тал руугаа тогоотой хоолны шим шүүс тунардаг юм бол нийгмийн амьдрал ч гэсэн буцалж, доргилж байгаа газраа биш ажиглаж байгаа, анаж байгаа газраа хамаг шим шүүсээ өгөх ёстой” гэж бодсон. Тэр бодлынхоо үр дүнгээр “Цагаан харх”-ыг бий болгосон аж. Өнөөдөр нам, холбоод байгуулагдаж л байна. Элдэв сүржин нэртэй эвсэл, фракциуд үүсч л байна. Намууд хоорондоо хөлөө жийлцэж л байна. Эцсийн дүндээ ямар ч үр ашиггүй байна. Харин “Цагаан харх” бол шал өөр. Засаг, төрийн эрхэнд ямар ч нам байгаагаас шалтгаалахгүйгээр үр шимээ амсч байна. Тийм болохоор саарал ордны буцлааны шим шүүсийг “Цагаан харх” идэж байгаа гэсэн үг билээ. Буурал толгойт буцалж буй хонины битүү толгойг нааш, цааш нь хэд эргүүлснээ тос тунарсан хэсэг рүү нь гүзээгээ болгочихоод буцаж суудалдаа тухлан сонинуудаа үргэлжлүүлэн уншиж гарлаа. Энэ үед ч гэсэн түүний толгойд мөнөөх л “Үл буцлах тал”-ын тухай онол нь эргэлдэж, “Монгол Улсын Ерөнхий сайдаар хэнийг болгох вэ гэдэгт би ч гэсэн өөрийн санал, сонирхлоо оруулна. Маргаашнаас эхлэн саарал ордон төдийгүй Монгол даяар даргилан буцална. Тэр буцлаанаас гарах шим шүүсийг би л амсч, хүртэх болно” гэж шүд зуун бодож байлаа.

Арвандолоо. Хонзон

Оройн найман цагт утасдана гэж бизнесмэн эр хэлсэн болохоор ордны тул цагийн зүүний хэмнэлийг зүрхнийхээ цохилтоос илүү мэдэрч байв. Түүний зүрх энэ удаа яагаад ч юм цагийн зүүнээс хамаагүй хурдан, ямар ч ритмгүй цохилж байгааг анзаарлаа. Цагийн зүү нэг л удаан залхуутай, хэн нэгэн хөлөө чирэн алхах шиг яаралгүй “цар, цар” хийн дуугарахыг сонсохоор уур нь хүрэх шиг, дотор нь бачимдах шиг болж байлаа. Энгийн үед цаг гэдэг санаанд оромгүй амархан өнгөрдөг бол хүлээсэн цагт цаг шиг удаан юм орчлон

дээр байдаггүй юм шиг түүнд санагдаж байв. Хараал идсэн энэ орой хурдан өнгөрөөсэй гэж тэр зүхэж байлаа. Аль болохоор хүний анхаарал татахгүй байхыг хичээж буй тэр оюутан цагийнхаа нөхрийг зориуд өдөн байж ёвчуур тоглох нэрээр тоглоомын ширээнд урьчихаад хэрэг дээрээ операци болж өнгөрөх цагийг хүлээж байгаа нь энэ билээ. Түүний тархи толгойд ёвчуурын бөмбөгний эгзэгтэй цэгийг олж цохин оноо авъя гэхээс хэд дахин илүүтэйгээр бизнесмэн эрийн ямар мэдээ өгөх нь сонин байлаа. Өчигдөр л хэд дахин утасдаад байсан “Цагаан харх”-ын эзний гарын хүн болох буурал толгойд өдрийн турш таг чиг байхаар бүр ч түгшүүртэй байв. Тэр “Цагаан харх”-ынхны занг мэднэ л дээ. Бүх зүйлийг тэд эхлүүлдэг, зохион байгуулдаг, тэгсэн хэрнээ хамгийн эгзэгтэй мөчид үхсэн юм шиг л алга болдчихдог юм. Ордны тулын хоёр нөхөр бие биенээ үгээр хатган илүү оноо авахын төлөө үхэлдэнэ. Тэдний “Хөөе, бух чинь уначихлаа”, “Чи наадхыгаа хэргээр өөрийн талын дунд нь хийчих”, “Шороон буланд нь хийлээ” гэх зэргээр өндөр дуугаар өгүүлэлдэх нь түүнд огт хүртээлгүй байв.

Тэр хоёрын хэн нь ялах, дараа нь өөрөө хэнтэй нь тоглох ч огт падгүй байв. Жир цагт мөрийний таван цаасаа алдахгүй гэж хөлсөө арчиж зүтгэдэг түүнийг өнөөдөр нэг л хэвийн бус байгааг тоглоомдоо улайрсан нөхөд нь ер анзаарсангүй. Ордны тулын толгойд мөнөөх бизнесмэн эрийг юу гэж хэлэх бол гэсэн түгшүүр л чөлөө завгүй эргэлдэж байв. Ордны тул хангалттай өндөр албан тушаалыг эрхэлж буй бөгөөд энэ албан тушаалаасаа тэр таван төр ч солигдсон ховхрохгүй нь тодорхой. Хувь заяаг нь бурхан багш шиг чиглүүлж байдаг “Цагаан харх”-ынхан байгаа газарт тэрбээр огт газардахгүй. Тэр “Цагаан харх” байгаа цагт би оршин тогтнож байх л болно гэж боддогоос биш “Цагаан харх”-ын оршин тогтнолт түүнгүйгээр бас төдийлөн хүчирхэг байж чадахгүй гэдгийг анзаардаггүй. Буурал толгойтын бүх л улс төрийн хорон явуулга түүнээр дамжиж, тэрбээр бүх хорыг нь гардан хийдэг ажгуу. Нүүрэн дээрээ буянтай хүний дүр үргэлж л эсгэж явдаг “Ордны тул”-ыг дотор санаандаа хичнээн их хорон бодол, атгаг хүсэл тээж явдагийг улс төрийн хүрээнийхэн төдийлөн мэдэхгүй. Түүний атгаг хүсэл бол бүх эрх мэдлийг ганцаараа эзэгнэх, хэмжээ хязгааргүй ноёрхлоо тогтоохын төлөө байдаг гэдгийг нь хавь орчных нь мэдвэл үргэж зугтахаар юм. Даанч тэрбээр тэр хүслээ хүний таван мэдрэхүйгээс нууж чаддагаараа онцгой билээ. “Цагаан харх”-ынхан С.Зоригийг хөнөөх гэж байгааг мэдээд тэр учиргүй баярласан. Нэр хүнд, албан тушаалаараа өөрийнх нь дээр байдаг ардчиллын лидерүүдэд тэрбээр яснаасаа дургүй. Тэд л анх 1990 онд “Ардчилсан холбоо” гээчийг байгуулж, нийгмийг үймүүлээгүй бол өдийд тэрбээр хуучны Улс төрийн товчооны гишүүн болчихсон цаашаа бүр Улс төрийн товчооны тэргүүлэгч болно гэж зүтгэж явах байхгүй юу.

Гай болж ардчиллагчид гарч ирэн түүний хамаг төлөвлөгөөг баллачихсан. Дараа нь тэр арга буюу ардчиллын давалгааг даган хөвөхгүй бол сөрөөд юу ч олохгүй юм байна гэж бодон ардчиллагчдын эгнээнд шургах гэж оролдож үзсэн. Ардчиллагчдын итгэлийг олох гэж тэр махаа идсэн. Худалч хүнд бол бараг л ардчиллагчдын лидерүүдийн гутлыг долоох

нь холгүй явсан. Түүнийг ардчиллагчдаас хэн нь ч тоож авч үзээгүй. Тэгж тэгж тэрбээр аль нэг улс төрийн хүчнийг биш аль алинд нь тал алдахгүй байж эрх мэдлээ хамгаалж явах гурав дахь замыг сонгох болсон юм. Мэдээж, түүнд нэгэн цагт зорилго, хүсэл нэгтэй байсан болохоор Ху намынхантай ойлголцох нь хялбар байдаг. Харин ардчиллынхан түүнд цаанаасаа нэг л ёозгүй ханддаг. Тиймээс түүнд энэ удаа ардчиллагчдаас тэр тусмаа бүх насаараа угсаа залгасан ноён шиг ээлж дараалалгүй эрх ямба эдлэх замаас нь хазайлгахад гол үүрэг гүйцэтгэсэн ардчиллын удирдагчдын нэг С.Зоригийг замаасаа зайлуулах нь таатай хэрэг байсан юм. Ардчиллагчдын дотроос С.Зориг бол хамгийн аюултай хүний нэг. “Цагаан харх”-аас С.Зоригийг зайлуулах тухай даалгавар ирэхэд тэрбээр хэмжээлшгүй их баярласан. Тэгээд яаж зайлуулах тухайгаа сайтар бодож, боловсруулсан. Гэтэл хэрэг дээрээ Зоригийг зайлуулах арга ажиллагаа нь тийм ч хялбар биш байсан болохоор тэр ер тайван байж чадахгүй байгаа юм. Бизнесмэн эр алдаж гишгэвэл тэрбээр давхар балрах учраас операци хэрхэн дуусах бол гэхээс өөрийн эрхгүй түгшиж байлаа. Тийм болохоор ёворцогондоо улайран өөр юуг ч эс анзааран бие биенээ үгээр утан хорыг нь малтаж, цаг хугацааг зугаатай өнгөрөөх оюутан цагийн нөхөд нь нэг л амар тайван, аз жаргалтай амьдарч байгаа юм шиг л санагдаж байлаа.

АРВАННАЙМ. ХОРОМ

Зориг өрөөндөө ганцаар аар шаархан бичиг баримтаа эмхлэн бодол болон суусаар цаг хугацааг хэрхэн өнгөрснийг анзаарсангүй. Нэг харахнээ гадаа хэдийнэ гэгээ тасарч харанхуй ноёлжээ. Тэрбээр тамхи татахаар халаасаа нэгжсэнээ гарахын хооронд тамхи асаагаад ч юугаа хийхэв гэж бодоод больчихов. Тэгтэл хааяа нэг цаг зав гарган алжаалаа тайлдаг шатар нь нүдэнд нь туслаа. Энэ шатрын хөлөгний ард тэр олон ч хүнтэй



тоглосон, олон ч удаа хожил авч байсан мөн төдий чинээ хожигдол хүлээж байсан билээ. Тэрбээр шатрынхаа хөлгийг харах зууртаа “Амьдрал өргөн утгаар нь авч үзвэл шатрын л хөлөг юм даа. Хожиж л байдаг, хожигдож л байдаг шатар гээч энэ тоглоом улс төртэй ч их адилхан юм. Гэхдээ шатар тоглоод хожигдож сураагүй нэг их шар хортой хүмүүс байдаг даа. Манай улс төрчдөд хожигдож сураагүй тийм нэг өвчин байх юм даа. Хүн хожигдож сурах хэрэгтэй. Бас хожиж ч сурах хэрэгтэй. Ингэхэд ер нь намайг Ерөнхий сайд болоё гэхэд дэмжих хүн нэлээн л байгаа юм байна. Дэмжихгүй хүмүүс ч олон байгаа юм байна. Тэгэхдээ яахав, би заавал явах ёстой ч юм биш. Дэвшээд л үзье. Олны дэмжлэг

авбал тэр л биз. Авахгүй бол тэр л биз. Тэглээ гээд аль ч тохиолдолд би хүнээрээ л байх ёстой. Хүн хүнээрээ байна гэдэг хамгийн том зүйл. Хүнээрээ байна гэснээс би чинь нээрээ шадар сайд агсан Пүрэвдорж гуайнхаар орох хэрэгтэй юм байна шүү дээ. Засгийн газраас намайг оршуулгын комисст нь оруулчихсан байгаа. Пүрэвдорж гуай хүнийхээ хувьд сайн хүн байсан. Ноён нуруутай, жинхэнэ төрийн хүн байсан. Төрийн хүн ямар байх ёстой вэ гэдгийг харуулж чаддаг ахмадууд манайд ч бас цөөнгүй байгаа шүү. Ямар ч байсан ажил үүргийнхээ хувьд ч, хүнийхээ хувьд ч талийгаачийнхаар ороод гаръя” хэмээн бодсоноо жолооч руугаа утасдан дуудлаа.

Жолооч нь “Ойрхон байна. Тав, аравхан минутын дараа очъё” гэсэн болохоор тэрбээр гарахаар гадуур хувцсаа өмслөө. Зориг гарах зууртаа өрөөгөө эргүүлж, тойруулж харснаа мөн л шатар дээрээ хараагаа тогтоогоод “Маргааш чинь хагас сайн өдөр. Тэгэхлээр нөхдүүдтэйгээ шатар тоглонгоо жаал зуул дэмий юм ярьдаг ч юм уу? Хавьд ажил ихтэй байсан болохоор шатар тоглож ер чадсангүй. Маргааш нэг сайхан шатар тоглоё” хэмээн бодоод гарлаа. Зоригийг гарахад жолооч нь хэдийнэ ирчихсэн хүлээгээд зогсч байлаа. Тэрбээр жолоочдоо талийгаачийнд очих тухайгаа хэлчихээд мөн л бодол болон суув. Түүний бодолд “За, тэгээд олонхийн дэмжлэг аваад Ерөнхий сайд боллоо гэхэд ажлаа хаанаас нь эхэлж таарахав? Нийгэмд намын нэр хүнд уначихсан байгаа болохоор олон нийт надад нэг л итгэлтэй хандахгүй байх. Аягүй л бол байдаг л нэг худлаа ярьдаг улс төрч л гэж хүлээж авах байх. Уул нь улс төрчид улс, орноо хэрхэн хөгжүүлэх талаар эхлээд боддог, дараа нь төлөвлөгөө гаргадаг, эцэст нь хэрэгжүүлдэг баймаар юм. Манай улс төрчид болохоор яг үүний эсрэг ерөөсөө боддоггүй, бодоогүй байж амладаг. Амласан зүйл нь хэзээ ч хэрэгжихгүй байдаг болчихоод байгаа юм. Энэ л манай улс төр дахь том алдаа юм. Би үүний эсрэг л зогсох ёстой. Үүний тулд бодох ёстой, бодсоныгоо сайтар боловсруулсан төлөвлөгөө болгох ёстой, эцэст нь хэрэгжүүлэх ёстой” гэсэн нэгэн үзүүрт санаа эргэлдэж байлаа. Зориг Пүрэвдорж агсныд нэг их удсангүй. Ар гэрийнхэнд нь хүндэтгэл үзүүлчихээд, ажил байдалтай нь танилчихаад гэр рүүгээ явахаар болов. Тэрбээр гэртээ очих замдаа ч мөн л нөгөө бодлоо үргэлжлүүлэн бодсоор байлаа.

Түүнд “Бид ард түмэндээ хөгжил дэвшлийг амлаж гарч ирсэн. Үүнийхээ төлөө хийсэн юм байгаа юу гэвэл байгаа. Нэг үеэ бодвол бидний тэмцлийн үр дүнд манай ард түмэн хувь хүний эрх чөлөөгөөр хангагдсан, эдийн засгийн эрх чөлөөгөөр хангагдсан. Гэхдээ үүндээ бид сэтгэл ханах ёсгүй. Хийх юм их байгаа. Монголын улс төрийн түүхэнд анх удаа улс төрийн залуу хүчин төрийн эрх барьж байгаа болохоор алдаа, оноо их байгаа. Бидний оноог маань бүдгэрүүлж, алдааг минь тодруулах гэсэн бодит хүчин оршиж байгаа юу? Оршиж байгаа. Орших оршихдоо бүр хүчтэйгээр оршиж байгаа. Тийм болохоор биднийг яаж ажилласнаар манай иргэдийн ардчилалд итгэх, ардчиллын үнэ цэнэд итгэх итгэл нь бэхжих нь гарцаагүй юм” гэсэн бодол санаа төрж байлаа. Зориг ийнхүү бодол болон явсаар гэрийнхээ үүдэнд буулаа. Тэрбээр жолоочдоо “Сайхан амраарай” хэмээн өгүүлчихээд гэр рүүгээ алхав. Тэгтэл түүнийг мөнөөх золбин гөлөг хүлээсэн янзтай орцных нь үүдэнд зогсч байлаа. Зориг нөгөө гөлгийг ер анзаарсангүйгээр барахгүй түрүү түрүүчийнхээ бодлыг үргэлжлүүлэн бодсоор орц руугаа оров. Тийнхүү бодолд дарагдан алхсаар гэрийнхээ үүдэнд очоод тэрбээр хаалгаа түлхүүрдлээ. Хаалганы цаана юу хүлээж байгааг, хорон муу санаатнуудын бодож боловсруулсан ямар их нүгэлтэй хар аюул хүлээж байгааг тэр даанч мэдсэнгүй.

АРВАНЕС. ЗҮҮДНИЙ ТӨГСГӨЛ

Операци “Цагаан харх”-ынхны төсөөлж байснаас дуулиантай болж өнгөрлөө. Аравдугаар сарын хоёрны шөнөөс хойш улс, орон даяар түгшүүрт байдал бий болж, цагдаа, хүчнийхэн алуурчдын араас мөрдөж эхэллээ. Буурал толгойт болсон үйл явдлын тухай сонин хэвлэлүүд дур дураараа таамаг төдий мэдээллүүд цацахыг үзээд “Яг л миний санаснаар боллоо. Энэ Зориг үнэхээр Ерөнхий сайд болсон бол олны дэмжлэгийг айхтар авахаар хүн байсан байна шүү. Түүхийн хүрдийг өөр тийш нь эргүүлж мэдэхээр нэр нөлөөтэй хүн байсан байна. Ингэж их дуулиан болно гэдэг чинь надад их л хортой зүйл. Би ер нь анхаарлаасаа Ордны тулыг салгаж болохгүй юм байна. Байдал эвгүйдвэл өрсөх л хэрэгтэй” хэмээн үзэж, мөнөөх эрийн араас хорин дөрвөн цагийн дагуул тавьж хяналтдаа авчээ. Ордны тул хэмээгдэгч эр мөнөөх бизнесмэн эрийг өөрт нь осолтой гэдгийг тооцож байгаа учраас “Цагаан харх”-ынханд нүдлүүлжээ. Энэ нь Буурал толгойтод бүр ч ашигтай зүйл байлаа. Буурал толгойт бизнесмэн эрийг мөн л хяналтдаа авч хэрэг бишидвэл Ордны тулд цагдаагийнхан хүрэхээс нь өмнө замаасаа зайлуулахаар мөн л цохонд нь онилжээ. Тэр тохиолдолд Буурал толгойт эхлээд бизнесмэн эрийг залгуулаад дараа нь Ордны тулыг хөнөөх төлөвлөгөөг давхар боловсруулжээ. Бизнесмэн эр төдий хэр бас л хар амиа аврахын тулд Ху овогтыг овоо хараандаа авч, эгзэгтэй үед устгахаар бас л нарийн тооцсон арга ажиллагаа сэджээ. Харин Ху овогт тэднээс шал өөр арга ажиллагаа сэдсэн байсан бөгөөд тэрбээр Зориг руу чиглэсэн операцийг Мөнхөөгөөр биш шал өөр хүмүүсээр, шал өөр замаар зохион байгуулж хийсэн билээ. Мөнхөөг тэр хөлслөхдөө операци бүтэлгүй болвол юуны өмнө араас ирэх аюулыг таслан зогсоох үүднээс Ордны тулыг устгуулахаар төлөвлөж байсан аж. Гэвч операци түүний төлөвлөсөн ёсоор хэрэгжсэн учраас тэрбээр Ордны тулыг хөнөөлгөх шаардлагагүй болж, үйл ажиллагаагаа санаанд орохын аргагүй өөр байдлаар дуусгажээ.

Мөнхөөгийн хувьд бол тэрбээр Ху овогтын нууц байрнаас даалгавраа гүйцэтгэх гэж гараад дахин хүний орчлонд харагдахгүй болсон юм. Учир нь, Мөнхөөг операци хамтарч хийх нэрээр Ху овогтын байрнаас дагуулж гарсан хүн нь уулын аман дахь эзгүй байшинд авч очжээ. Мөнхөө тэр байшинд яг юу болох гээд байгаа талаар ер хар аваагүй бөгөөд тэнд тэрбээр зүүдэнд үзсэн золгүй явдалтайгаа өөрийн биеэр учирсан юм. Мөнхөө Ху овогтын захиалгыг гүйцэтгэхчээд дараа нь яаж амиа хоохойлох тухай бодож байснаас биш түүнээс нь өмнө өөрийнх нь хоолой дээр эрлэгийн соёо зоогдохыг даанч төсөөлөөгүй билээ. Тэр үед тэрхүү уулын аман дахь эзгүй байшинд олон хоног сойгдсон том азарган нохой хамтрагчийнх нь ганц дохилтоор хоолой руу нь ноцон дайрчээ. Тэрхэн мөчид тэрбээр нохойн нүднээс өөрийнхөө айсан дүрийг олж харж билээ. Тэгэхэд түүнд хоромхон зуурын төдий хоёр бодол зэрэг төрсөн юм. Эхнийх нь зүүдэндээ л итгэдэг байж гэсэн харамсал, хоёр дахь нь би дахиад зүүдэлж байгаа байх гэсэн горьдлого байсан юм. Тэгээд түүнээс хойш юу болсныг тэр даанч мэдээгүй бөгөөд мэдсэн бол цагдаагийн шуурхай мэдээлэлд Учрал гэсэн тод хар хөмсгийн дор “Хэн нь тогтоогдоогүй гуч гаруй насны 1 метр 65 см орчим биетэй эрэгтэй хүн чононд бариулж нас барсныг эрэн

сурвалжилж байна” гэсэн мэдээг лав унших байсан биз. Гэхдээ түүнийг чоно огт бариагүй гэж бодож болохгүй юм. Учир нь, нохойд хоолойгоо тасдуулж үхсэнээс нь хойш хэдхэн цагийн дараа үнэхээр өлсгөлөн чонын сүрэг түүний цогцсыг хангалттай сайн мөлжиж орхисон билээ... хэмээсэн энэхүү зохиолыг ХБНГУ хотноо 2000 оны гуравдугаар сард тэрлэснээ 2008 оны дөрөвдүгээр сард Улаанбаатар хотноо дахин нягталж сийрүүлээд уншигчдадаа хүргэлээ.